

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

**ОРШИЛ**

Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу 4 багц, 14 үзүүлэлтээр дүгнэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн тайлан, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт, салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явцад 2016 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангууд, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар /ХХААГ/-ын 2016 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, яамны хэрэглэгчийн үнэлгээний тайлан, Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-оос гаргасан Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2016 оны эмхэтгэл, 2016 оны 12 сар, Хөдөө аж ахуй 2015 эмхэтгэл, Гаалийн ерөнхий газраас гаргасан Гадаад худалдааны барааны статистик 2016/12 болон гүйцэтгэлийн үр дүнг нотлох холбогдох материалууд, хэрэгжүүлэгч газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2016 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2016 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгийн ерөнхий үнэлгээ **87.0** хувь буюу **4.35** оноотой байна.

**1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

**1.1 ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/ дангаар болон толгойлон хэрэгжүүлэхээр тусгагдсан 62 зорилтын 160 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эдгээр зорилт, арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагууд болон яамны нэгж, газрын тухайн жилийн төлөвлөгөө, холбогдох албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцын мэдээллийг яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээ.

Нийт арга хэмжээнээс 2016 оны жилийн эцсийн байдлаар 3 арга хэмжээ 50 хувь, 48 арга хэмжээ 30 хувь, 84 арга хэмжээ 10 хувийн биелэлттэй байна. Харин 22 арга хэмжээг үнэлэх хугацаа болоогүй, 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй байлаа. Тус салбарын хяналтад авсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 18.0 хувь байгаа нь 2016 онд хүрвэл зохих түвшинг хангалттай биелүүлсэн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээнд төлөвлөгдсөн 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт дунджаар 20.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хүрээнд 43 зорилтын 130 арга хэмжээний биелэлт дунджаар 18.1 хувь, Нийгмийн бодлогын хүрээнд 3 зорилтын 5 арга хэмжээний биелэлт дунджаар 23.3 хувийн биелэлттэй дүгнэгдлээ. Харин аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан 23 заалтын 15 нь үнэлэгдээгүй бол үнэлэгдсэн 8 заалтын хэрэгжилт хамгийн бага буюу дунджаар 10.0 хувь байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн дээр тулгуурлан дараагийн шатны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулж тус яамны холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байгаа болно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ  
(2016 оны жилийн эцсийн байдлаар)**

Хүснэгт 1

Бүлэг	Тэргүүлэх зорилтын душаар	Зорилт ын тоо	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт, өссөн дүнгээр /хувь/
				50	30	10	ХБ	ҮБг	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	2	2	=	1	1	=	=	20.0
Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	2.1.	3	3	=	=	3	=	=	10.0
	2.2.	40	127	3	45	71	8	=	18.6
Гурав. Нийгмийн бодлого	3.1.	1	1	=	1	=	=	=	30.0
	3.2.2.	2	4	=	1	1	2	=	20.0
Зургаа. Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтууд	6.1-6.21	17	23	=	=	8	12	3	10.0
Дүн			160	3	48	84	22	3	<b>18.0*</b>

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ХХААХҮЯ-ны 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/343 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-т хүргүүлж, яамны цахим хуудасны “Ил тод байдал” булангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хэсэг болон дотоод сүлжээний АСУ программын “Лавлах, Файлын сан” булангийн Төлөвлөгөө, тайлан гэсэн хэсэгт тус тус байршуулсан.

\* Төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 2016 оны жилийн эцсийн байдлаар 3 арга хэмжээ 50 хувь, 48 арга хэмжээ 30 хувь, 84 арга хэмжээ 10 хувийн биелэлттэй байна. Харин 22 арга хэмжээг үнэлэх хугацаа болоогүй, 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна. Тус салбарын хяналтад авсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 18.0 хувь байгаа тул 2016 онд хүрвэл зохих түвшинг "хангалттай сайн" буюу **100** хувь биелүүлсэн гэж дүгнэж байна.

**1.2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/30 дугаар тушаалаар “Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүллээ. Уг төлөвлөгөөний дагуу “Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого”-ын хүрээнд 6 зорилтод хамаарах 35 арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2016 оны жилийн эцсийн байдлаар **80.3** хувьтай үнэлэгдэв. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 16 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 8 арга хэмжээ 90.0 хувьтай, 3 арга хэмжээ 70.0 хувь, 5 арга хэмжээ 50 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол 3 арга хэмжээ 10 хувийн хэрэгжилттэй байв. Тасарсан арга хэмжээ байхгүй болно.

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧООН**

(2016 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 2

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар							Дүнд аж, %
			100	90	70	50	30	10	0	
- Макро эдийн засгийн бодлого; - Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого; - Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого;	6	35	16	8	3	5	-	3	-	80.3

Арга хэмжээг хэрэгжүүлэхэд 75.99 тэрбум төгрөг төлөвлөснөөс 10.9 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн дүнгийн дөнгөж 14.3 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн шалтгааныг дурдвал хүрэх түвшингээ хэт өндөр тавьсан, эсвэл шалгуур үзүүлэлтүүд арга хэмжээнийхээ агуулгаа бүрэн илэрхийлж чадахгүй, оновчгүй сонгогдсонтой холбоотой төлөвлөлтийн алдаа, нөгөө талаар богино хугацааны бодлогын баримт бичиг төлөвлөж буй тул хугацааг тооцох, мөн түүнчлэн хэрэгжилтийг тайлагнах талаар төдийлөн ач холбогдол өгдөггүй, шат шатны байгууллага хариуцсан хүмүүсийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна. Энэ талаар хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжид тодорхой дурдсан болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны цахим хуудасны “Ил тод байдал” булангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хэсэг болон дотоод сүлжээний “АСУ” программын “Лавлах, Файлын сан” булангийн Төлөвлөгөө, тайлан хэсэгт тус тус байршуулав.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ХХААХҮЯ-ны 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/274 тоот албан бичгээр Сангийн яаманд, 31-ны өдрийн 01/344 тоот албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлэв.

### 1.3 УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан нийт 96 тогтоол, шийдвэрийн 158 заалтаас ХХААХҮ-ийн яамны үндсэн чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл нийлсэн нийт 92 тогтоол, шийдвэрийн 152 заалтыг тус яам хяналтад авч хэрэгжүүлж байна.

Эдгээр заалтын хэрэгжилтэд 2015 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 57(36.7хувь) заалт бүрэн биелсэн, 88(65.2хувь) заалт хэрэгжилтийн шатанд, 1 заалтын хэрэгжилт тасарч, биелэлтийн дүн дунджаар **85.2** хувьтай үнэлэгдэв. Мөн хэрэгжилтийн хугацаа болоогүй 6 заалтыг дүгнээгүй тул үнэлгээнд оруулаагүй болно. Хяналтад авсан нийт тогтоол шийдвэрийн 61.5 хувь нь 2015 онд шинээр батлагдсан байна. Шинээр гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай зохион байгуулагдаж байгаа нь хууль, тогтоомжийн биелэлтийн явц, үр дүнгээс харагдаж байна.

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ (2016 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 3

Тогтоол, шийдвэрийн биелэлтийн тоо, хувиар	Бүгд	Үүнээс											
		Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Шинэ засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	<b>147</b>	12	14	6	5	51	11	51	0	4	4	0	
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо	<b>245</b>	34	26	12	14	66	19	77	0	4	12	0	
Үүнээс	Биелсэн 100.0 хувь	<b>105</b>	12	12	2	5	33	14	33	-	3	4	-
	Хэрэгжих шатанд:	<b>124</b>	<b>18</b>	<b>11</b>	<b>10</b>	<b>7</b>	<b>28</b>	<b>5</b>	<b>42</b>	-	-	<b>8</b>	-
	90.0 хувь	<b>41</b>	1	4	4	3	9	1	17	-	-	3	-
	70.0 хувь	<b>35</b>	3	1	1	-	13	2	15	-	-	2	-
	50.0 хувь	<b>20</b>	4	3	3	-	4	-	4	-	-	2	-
	30.0 хувь	<b>22</b>	9	3	2	2	2	2	4	-	-	-	-
10.0 хувь	<b>6</b>	1	-	-	2	-	-	2	-	-	1	-	

	Хугацаа болоогүй	6	1	1	-	2	1	-	1	-	-	-	-
	Дүгнэгдээгүй	9	2	2	-	-	4	-	1	-	1	-	-
	Тасарсан	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Ерөнхий дүн	79.8	63.9	81.3	70.0	70.1	86.5	88.9	82.9		100	76.7	

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2016 оны жилийн эцсийн байдлаар ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан нийт 147 тогтоол, шийдвэрийн 245 заалтаас тус яамны үндсэн чиг үүрэгт хамаатай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл нийлсэн нийт 147 тогтоол, шийдвэрийн 245 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийсэн. Дээрх заалтуудын 105 нь бүрэн биелэгдсэн, 124 заалт хэрэгжилтийн шатанд байгаа ба биелэлтийн дүн дунджаар 79.83 хувьтай үнэлэгдэв. Тодруулбал, 41 заалт 90 хувиар, 35 заалт 70 хувиар, 20 заалт 50 хувиар, 22 заалт 30 хувиар, 6 заалт 10 хувиар тус тус үнэлэгдэж, 1 заалт тасарсан байна. Хэрэгжилтийн хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 6 заалт байгаа бол эрхлэх асуудлын үндсэн чиг үүрэгт хамааралгүй, мөн шийдвэр гарсны дараа ямар нэг үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байхад хүчингүй болсны улмаас хэрэгжилтэд үнэлгээ өгөөгүй нийт 9 заалт байгааг тодрууллаа.

Монгол Улсын Хуулийн хяналтад авсан 12 зүйл заалтын 34 заалт хяналтад авсны 12 заалт бүрэн хэрэгжсэн, 18 заалт хэрэгжих шатанд байгаагаас 1 заалт 90.0 хувь, 3 заалт 70.0 хувь, 4 заалт 50.0 хувь, 9 заалт 30.0 хувь, 1 заалт 10 хувь, 1 заалт хугацаа болоогүй, 1 заалт чиг үүрэгт тохирохгүй тул дүгнэгдээгүй, 1 заалт тасарсан гэж тус тус үнэлэгдэв.

Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны 20 тогтоолын хяналтад авсан 38 заалтын 14 нь бүрэн биелэгдэж, 21 заалт хэрэгжих шатанд байгаагаас 8 заалт 90.0 хувь, 2 заалт 70.0 хувь, 6 заалт 50.0 хувь, 5 заалт 30 хувиар үнэлэгдэв. Хугацаа болоогүй хүлээгдэж буй 1 заалт байгаа бол 2 заалт чиг үүрэгт тохирохгүй улмаас дүгнэгдээгүй болно.

Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хяналтад авсан 5 зарлигийн 14 заалтын 5 заалт бүрэн хэрэгжсэн бол 7 заалт хэрэгжилтийн шатанд байгаагаас 3 заалт 90 хувь, 2 заалт 30 хувиар үнэлэгдэж, 2 заалт 10 хувиар үнэлэгдэж, 2 заалт хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Засгийн газрын хяналтад авсан 51 тогтоол шийдвэрийн 66 заалтаас 33 заалт бүрэн хэрэгжсэн, 26 заалт 50-90 хувьтай, 2 заалт 30 хувиар, хугацаа болоогүй хүлээгдэж буй 1 заалт, чиг үүрэгт хамаарахгүй тул дүгнэгдээгүй гэсэн 6 заалт байна.

Харин шинэ Засгийн газрын 11 тогтоол шийдвэрийн 19 заалтаас 14 заалт бүрэн хэрэгжсэн, 3 заалт 70-90 хувьтай, 2 заалт 30 хувиар үнэлэгдсэн.

Засгийн газрын хуралдааны 51 тэмдэглэлийн 77 заалтыг хяналтад авч ажилласнаас 33 заалт бүрэн биелж, 42 заалт хэрэгжих шатанд буюу 10.0-90.0 хувийн биелэлттэй, хугацаа болоогүй хүлээгдэж буй 1 заалт, чиг үүрэгт хамаарахгүй тул дүгнэгдээгүй 1 заалт байна.

Ерөнхий Сайдын захирамж 4 тогтоол шийдвэрийн 4 заалтаас 3 заалт бүрэн хэрэгжсэн, чиг үүрэгт тохирохгүй дүгнэгдээгүй 1 заалт байна. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 4 зөвлөмжийн хяналтад авсан 12 заалтаас 4 заалт бүрэн хэрэгжсэн хэрэгжих шатанд 8 заалт тус тус үнэлэгдэв. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудаас бүрэн хэрэгжсэн болон хугацаа нь дууссан, цаг үеийн асуудлаар гарч зохих үр дүнд хүрсэн 120 заалтыг хасуулах саналтай байна. Саналын үндэслэл нь тогтоол, шийдвэрийн зарим заалт бүрэн хэрэгжсэн, мөн хүчингүй болсон, хугацааны хувьд ач холбогдолгүй, төсөв нь татагдсан, хөрөнгө оруулалт байхгүй зэрэг болно.

#### ХЯНАЛТААС ХАСУУЛАХ ЗААЛТУУД (2016 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 4

д/д	Эрх зүйн баримт бичиг	Шийдвэрийн тоо	Хасах заалтын тоо
1	Монгол Улсын хууль	12	9
2	Улсын Их хурлын тогтоол	14	11
3	Ерөнхийлөгчийн зарлиг	5	4
4	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	6	4
5	Засгийн газрын тогтоол	51	41
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	51	45
7	Ерөнхий сайдын захирамж	4	4
8	ҮАБЗ-ийн зөвлөмж	4	2
	Нийт	147	120

Дээд шатны байгууллагын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар багагүй ажил хийгдэж байгаа боловч биелэлтийг тогтоосон цаг хугацаанд багтаан бүрэн авч, ажлын гол үр дүнг товч тодорхой баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар хангалтгүй байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хяналтаас хасуулах заалтын жагсаалтын хамт ХХААЯ-ны 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/128 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны цахим хуудасны “Ил тод байдал” булангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хэсэг болон дотоод сүлжээний АСУ программын Лавлах, Файлын сан булангийн Төлөвлөгөө, тайлан хэсэгт тус тус байршуулав.

#### 1.4 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Тайлант хугацаанд ХХАА-н сайдын эрхлэх асуудлын хүрээнд УИХ, Засгийн газраас баталсан 5 хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад 2015 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийн, үр дүнд үнэлгээ өгөв. Хөтөлбөрүүдийн 2015 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээ **84.9** хувьтай дүгнэгдлээ.

#### ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ (2016 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 5

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтад авсан заалт	Тухайн жилд хийсэн ажлын үнэлгээ (хувь)
A	1	2	3	4
<b>Хүнсний салбар</b>				
1	“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр Засгийн газрын тогтоол, 2009.02.04 №32 Засгийн газрын тогтоол, 2011.04.13 №114	2009-2016	13/86	85.4
2	“Мах” хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2015.12.14 №492	2016-2017	1/5	87.5
<b>Мал аж ахуйн салбар</b>				
3	“Монгол мал” хөтөлбөр, УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол	2010-2021	5/87	71.3
<b>Газар тариалангийн салбар</b>				
4	“Чацаргана” хөтөлбөр, I үе шат Засгийн газрын тогтоол, 2010.03.10, № 60	2010-2016	5/36	95.6
<b>Хөнгөн үйлдвэрийн салбар</b>				
5	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2009.09.30 № 299	2009-2016	-	87.3
6	Хэвлэлийн үйлдвэрлэл хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2008.02.13 №53	2008-2016	-	89.0
7	Ахуй үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2014.08.28 №279	2014-2016	-	80.8
<b>Жижиг, дунд үйлдвэрийн салбар</b>				
8	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2009.06.10 №173	2009-2017	-	85.0
9	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, 2014.08.28 №178	2014-2016	-	81.2
Дундаж дүн				<b>84.8</b>

##### 1.4.1 Хүнсний салбарт хэрэгжсэн хөтөлбөрүүд

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн 13 зорилтыг хангах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны 2016 оны гүйцэтгэл дунджаар **85.4**, үр дүнгийн үзүүлэлт **74.7** хувьтай үнэлэгдэв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүнс, хөдөө аж ахуйн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад 118.5 сая төгрөг тусган зарцуулсан. Хүнсний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд зээл олгох, дэмжлэг, урамшуулал үзүүлэх хүрээнд улсын төсвөөс нийт 32,8 тэрбум төгрөг зарцуулсан тооцоолол байна.

**Төслийн зорилт, хэрэгжилтийн үр дүн.** Хөтөлбөрийн зорилтыг хангахын тулд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 13 зорилтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон ЭМЯ, БСШУСЯ, БОАЖЯ, ХНХЯ, МХЕГ, ОБЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ, үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэд хамтран хэрэгжүүлсэн байна.

Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль, тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

- ❖ Органик хүнсний тухай хууль,
- ❖ Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр,
- ❖ “Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт”-ыг Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 64 дүгээр тушаалаар тус тус батлуулав.
- ❖ Мөн түүнчлэн Хүнсний аюулгүй байдалтай холбогдох “Малын генетик нөөц”-ийн тухай, “Мал, амьтны эрүүл мэнд”-ийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2016 өргөн бариад байна.


Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

1. Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох хуулийг УИХ-аас 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр баталсан. Уг хэлэлцээрийн хүрээнд гаалийн үйлчилгээг шуурхай болгох, бараа бүтээгдэхүүн, дамжин өнгөрөх тээврийг чөлөөтэй нэвтрүүлэх, үл ялгаварлах зарчмыг баримтлах, худалдааны зардлыг бууруулах, техникийн туслалцаа үзүүлж чадавхийг бэхжүүлэх боломж, нөхцөл бүрдэнэ.

2. Үр тарианы үйлдвэрлэлд 2016 онд нийт 33.2 тэрбум төгрөгийн, үүнээс буудайн урамшуулалд 16 тэрбум, шатахуунд 9.4 тэрбум, үрийн буудайнд 7.8 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Дарханы УГТХ-тэй 2016 онд гэрээ байгуулан захиалгаар улаан буудайн нутагшсан 4 шинэ сортын 344 тн элит үр, арвай, хөх тариа, хошуу будаа, вандуйн нутагшсан шинэ сортын 180 тн элит үрийг хүлээн авч үрийн нөөц бүрдүүлэв. Хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор 2016 онд “КР-2” төслийн санхүүжилтээр нийт 7.8 мянган тн эрдэс бордоог 378 аж ахуйн нэгжид 60 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, мөн ТЭДС-гаас 288 аж ахуйн нэгжид нийт 233.3 тн ургамал хамгааллын бодисыг 30 хувийн урьдчилгаатайгаар тус тус олгох ажлыг зохион байгуулжээ.

3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд хүнсний үйлдвэрлэлийн салбарт 36 төсөлд нийт 12.67 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Энэ дэмжлэгийн үр дүнд хүнсний чиглэлээр 82 үйлдвэр шинээр байгуулагдаж, 225 үйлдвэрт өргөтгөл хийгдсэн байна. Зээлийн батлан даалтын сангаас 2016 онд жижиг, дунд үйлдвэрийн төслүүдэд нийт 37.8 тэрбум төгрөгийн батлан даалтыг хийсэн байна.

4. Махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр БНХАУ руу 2016-2018 онд 6.0 тэрбум юанийн өртөг бүхий 150.0 мянган тн мах үхэр, хонины мах нийлүүлэх санамж бичгийг үзэглэсэн, махны үйлдвэрүүдэд импортлогч улсын холбогдох байгууллагуудтай хамтран хянан магадлагаа явуулж, БНХАУ руу мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхийг давхардсан тоогоор 11 үйлдвэр, БНСВУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхийг давхардсан тоогоор 8 үйлдвэрт тус тус олгосон. Засгийн газрын 2015 оны 461 дүгээр тогтоолоор Сүхбаатар аймгийн Бичигт, Увс аймгийн Тэс, Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Говь-Алтайн Бургастай боомтоор түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боломжийг нээсэн байна.



- Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомт
- Мал экспортлох боомт
- ◆ Мал, мах экспортлох зөвшөөрөлгүй боомт
- Мал төхөөрөх 41 үйлдвэр
- Дулааны аргаар махан бүтээгдэхүүн боловсруулах 17 үйлдвэр

Бүдүүвч зураг  
1. Мал, мах экспортлох боомтууд

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхыг сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

❖ Стандарт, хэмжил зүйн газраас Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагаа “MNS ISO/IEC 17025:2007” стандартын шаардлагад нийцсэн тул 2016 оны 5 дугаар сарын 27-нд 3 жилийн хугацаатай давтан итгэмжилсэн.

❖ Улсын хэмжээнд 2016 оны байдлаар хүнсний бүтээгдэхүүний сорилтын итгэмжлэгдсэн 66 лаборатори үйл ажиллагаа явуулж байна.

❖ Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага “MNS ISO/IEC 17025:2007 стандартын сургалтыг 2015 онд 6 удаа зохион байгуулж, 203 хүнийг, 2016 онд 7 удаа зохион байгуулж 277 хүнийг тус тус хамруулсан байна.

Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах зорилтын хүрээнд:

1.Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу жишсэн хүн амын 2016 оны хүнсний хангамжийг урьдчилан тооцож үзэхэд гол нэрийн 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний 78 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хүнсний хангамж харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.

#### Хүснэгт 6

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн	Дотоодын үйлдвэрлэл мян.тн	Импорт, мян.тн	Экспорт, мян.тн	Нийт, хэрэглээ мян.тн	Хангамж, хувь
Мах, махан бүтээгдэхүүн	179.4	398.1	12.8	6.7	404.2	225.3
Сүү	134.7	474.2	23.1	8.9	488.4	362.6
Сүүн бүтээгдэхүүн	179.4	118.7	4.1	0.04	122.8	68.4
Гурил	89.7	60.0	138.4	2.2	196.2	
Гурилан бүтээгдэхүүн	197.3	55.1	17.9	0.5	72.5	36.7
Төрөл бүрийн будаа	70	0	24.2	0.5	23.7	33.9
Саахар, чихрийн зүйл	20.6	0	89.2	0.3	88.9	431.6
Төмс	125.6	163.8	42.3	0	206.1	164.1
Хүнсний ногоо	179.4	72.3	80	0.8	151.5	84.4
Жимс, жимсгэнэ	161.4	2.1	37.4	1.2	38.3	23.6
Буурцагт ургамал	80.8	0	4.9	0	4.9	6.1
Өндөг	17	4.6	3.1	0	7.7	50.7
Хүнсний тос	22.4	1.6	19.7	0.4	20.9	93.3

2016 оны урьдчилсан дүнгээр төрөл бүрийн будаа, сахар, чихрийн зүйл, буурцагт ургамлын хангамж импортоос бүрэн хамааралтай байна.

Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах зорилтын хүрээнд:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа гадаад улс, олон улсын байгууллагын 10 гаруй төслийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна.

2.Сүүний боловсруулах үйлдвэрүүдийн зүгээс сүү цуглуулж авах тогтолцоог сайжруулах зорилгоор сүүний хөргөлтийн төвүүдийг байгуулсан байна.

#### Хүснэгт 7

д/д	Үйлдвэрийн нэр	Хөргөлтийн төвийн тоо
1	АПУ	14
2	ТЭСО	14
3	Эн Жи Жи	17
4	Монфрэш сүү	6
5	Сүү	21
	<b>НИЙТ</b>	<b>72</b>

*Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах зорилтын хүрээнд:*

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам” болон Засгийн газрын 2012 оны 248 дугаар тогтоолоор баталсан байршил, нэр төрөл, тоо хэмжээнд нь бүрдүүлж, технологийн дагуу хадгалж байна.

*Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:*

1.Хөтөлбөр хэрэгжих хугацаанд “Гацуурт” махны үхрийн аж ахуй-махны үйлдвэр, “Ажигана” ХХК-ийн “Оргио” тахианы аж ахуй-үйлдвэр, “Мон таримал” ХХК-ийн сүүний ферм-сүү боловсруулах үйлдвэр, “Хишигтэн нүүдэлчин” ферм -сүү боловсруулах үйлдвэр, “Арвин хур” ХХК-ийн газар тариалан - ургамлын тос, гурвалжин будаа, шарсан төмсний үйлдвэр, “НБИЦ” ХХК-ийн өндөглөгч тахиа - өндөгний үйлдвэр, “Тайширын хүлэг” ХХК-ийн сүүний ферм - сүүний үйлдвэр, мөн орон нутагт 11 гурилын үйлдвэр-газар тариалангийн цогцолбор бий болсон байна.

2.Улсын хэмжээнд 2016 оны байдлаар сүү боловсруулах 211 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Сүү боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 928 сая л/жил болж нэмэгдсэн. Гэвч суурилагдсан нийт хүчин чадлын 10 хүрэхгүй хувийг ашиглаж байна.

Хүснэгт 8

Оноор	2012	2013	2014	2015	2016*
Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сая.л	72.8	63.9	71.1	70.3	73.1

3.Улсын хэмжээнд 2016 оны байдлаар мал төхөөрөх 41 үйлдвэр, цех байгаагаас 22 нь үйл ажиллагаа явуулж байна. Мал төхөөрөх үйлдвэрүүд жилд нийт 2 сая бог, 463 мян толгой бод мал нядлах суурилагдсан хүчин чадалтай. Гэвч суурилагдсан хүчин чадлынхаа 11.4 хувийг ашиглаж байна.

Хүснэгт 9

Оноор	2012	2013	2014	2015	2016*
Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, мян тн	13.2	19.6	16.8	17.5	15.3
Махны экспорт, мян.тн	3.7	3.8	2.57	5.2	8.2

*Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгааг хангах зорилтын хүрээнд:*

1.НАССР тогтолцоог нэвтрүүлсэн “Мах Маркет” ХХК нь дотоод хяналтын лабораториор итгэмжлүүлснээр бүтээгдэхүүнээ давтан шинжилгээ хийлгэхгүйгээр экспортод гаргах боломжтой болсон.

2. Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 7 компани /Спирт бал бурам ХХК, түүний УБ дахь салбар үйлдвэр, АПУ ХК, Трансинконсулт ХХК, Увс хүнс ХХК, Витафитинвест ХХК, “Арвайн үндэс” ХХК-д Чанарын удирдлагын тогтолцоо (ISO9001 олон улсын стандартын дагуу), Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо (ISO 22000 олон улсын стандартын дагуу)-г нэвтрүүлсэн гэрчилгээ аваад байна.

*Хүнсний аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд:*

1. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар дээр хэрэгжиж байгаа “Нэгдсэн төв лабораторийн барилга барих, техникийн чадавх бэхжүүлэх” төслийн хүрээнд нэгдсэн лабораторийг ашиглалтад оруулсан.

2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах бие даасан Хүнсний лавлагаа лаборатори байгуулж, техник, тоног төхөөрөмжөөр хангав.

## Дүгнэлт

- ❖ Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн 2016 оны индексийг 2010 оныхтой харьцуулахад 139.5 хувь, үүнээс мах, загас, жимс, ногоо, өөх тос боловсруулалт 119.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 158.2 хувь, үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл 134.1 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 144.1 хувь буюу төрөл тус бүрээр 19.6-58.2 хувиар өссөн дүнтэй байна.



- ❖ “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу тооцоход гол нэрийн 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүний 78.0 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хүнсний хангамж харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна.
- ❖ 2016 онд 38.0 мянган тонн мах экспортлох зорилттой байсан хэдий ч 8.2 мянган тонн (зорилтот түвшин 22 хувь) мах гадаадад гаргасан байна.
- ❖ Хүнсний ногоо, өндөгний хэрэгцээг бүрэн, цөцгийн тосны 20, загасны 25, жимсний 15, будааны 5, ургамлын тосны 40-өөс доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон байх зорилттой ажилласан боловч 2016 оны байдлаар хүнсний ногооны 47.7 хувь, өндөгний 59.5 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Жимсний 5.5 хувь, ургамлын тосны 7.7 хувийг үндэсний үйлдвэрлэлээр хангаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.
- ❖ Хүнсний үйлдвэрүүдийн 60 хувьд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтэрсэн байхаар заасан, мал нядлах, мах боловсруулах 2, тахиа төхөөрөх 1 аж ахуйн нэгж аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ыг нэвтрүүлээд байгаа нь анхаарвал зохих асуудал юм.

### **Зөвлөмж**

- ❖ Дотоодын мах боловсруулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр хөнгөлттэй зээл олгож, нөөцийн мах бэлтгэл болон мах экспортыг жигд нэмэгдүүлэх шаардлагатай. Хүнсний тухай хуулинд заасны дагуу нөөцийн мах бэлтгэлийг орон нутагт хариуцуулах, ХХААХҮЯ-ны оролцоог багасгах,
- ❖ Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр удаашралтай, хангалтгүй биелэлттэй гарсан хүнсний ногоо, өндөг, цөцгийн тос, загас, жимс, ургамлын тосны үйлдвэрлэлтэй холбоотой зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангахад анхаарч ажиллахыг,
- ❖ Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй, дотоодод үйлдвэрлэсэн ч нэгж бүтээгдэхүүний өртөг гарах цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнийг заавал эх орондоо тариалах ургуулах, боловсруулахыг зорилгүй, импортоос хангаж байхаар тогтож, бодлого, шийдвэрт тусгахыг,
- ❖ Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд 2012 онд батлагдснаас хойш үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) болон аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ыг нэвтрүүлэх талаар яам, хяналтын байгууллага, олон улсын төслийн хүрээнд олон тооны сургалт явуулсан боловч нэвтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо цөөхөн байх тул сургалтын үр дүн муутай, хяналт сул, үр дүнг тооцох аргачлал байхгүй тул салбарын хэмжээнд сургалтын талаар мөрдөх журам гаргах, мөрдүүлэх, сургалтын үр дүнг тооцох кредитийн нэгдсэн систем бий болгохыг,
- ❖ Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), үйлдвэрийн эрүүл ахуйн зохистой дадал (GHP), үйлдвэрийн зохистой дадал (GMP) нэвтрүүлсэн хүнсний үйлдвэрүүдийн дэмжих, алдаршуулах, бусдад туршлага дамжуулах талаар яамнаас санаачлага гаргах, үл нэвтрүүлсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хуулийн заалт дагаж мөрдүүлэх талаар арга хэмжээ авахыг тус тус зөвлөмж болгож байна.

### **“Мах” хөтөлбөрийн зорилго, санхүүжилт, үр дүн**

**Хөтөлбөрийн зорилго.** Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах, улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд мал бэлтгэж төхөөрдөг, мах боловсруулдаг болон зоорь бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид зээл олгох, дэмжлэг үзүүлэх.

**Хөтөлбөрийн санхүүжилт.** Хөгжлийн банкнаас аж ахуйн нэгжүүдэд дотоодын хэрэгцээний махны нөөц бүрдүүлэхэд 25,0 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлээд байна.

#### **Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт, үр дүн**

1.Махны нийлүүлэлт, хангамжийн талаарх Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2016 онд малын хэрэглээний зарлага 12.8 хувиар буурсан хэдий ч зах зээлд худалдан борлуулсан малын тоо 2.3 хувиар өссөн дүнтэй байна.

## Хүснэгт 10

д/д	Үзүүлэлт	2015 он	2016 он	2016/2015
1	Малын хэрэглээний зарлага, мян.толгой	14556.7	12700.0	87.2
2	Зах зээлд худалдан борлуулсан малын тоо, мян.тол	6650.9	6803.2	102.3

2.Хөтөлбөр хэрэгжих хугацаанд малын махны экспорт 1.9 дахин нэмэгдсэн байна. 2015 оны эхний 12 сарын байдлаар 10193.6 мянган долларын 4.8 мянган тонн малын мах экспортолсон бол 2016 онд 16858.6 мянган долларын 9.2 мянган тонн махыг гадаадад гаргасан байна. “Мах” хөтөлбөрт оролцогч “Дархан meat фүүдс” ХХК 2016 онд 2900 тн үхэр, адуу, “Эрдмийт” ХХК 600 тонн үхрийн мах ОХУ, БНХАУ-д экспортолсон нь нийт экспортын 38 хувийг эзэлж байна.

3.Махны үнэ хамгийн өндөр байдаг 5дугаар сард махны үнийн өсөлтийг бууруулж, зах зээлийн махны үнээс 17-32 хувийн хямд үнээр хэрэглэгчдэд мах нийлүүлж, үнэ тогтворжуулсан.

## Хүснэгт 11

д / д	Махны төрөл	аж ахуйн нэгжийн дундаж үнэ, төг/кг	2016 оны 05 сарын сүүлийн махны зах зээлийн дундаж үнэ, төг/кг	2016 онд нөөцөлсөн махборлуулах үнэ, төг/кг	Зах зээлийн дундаж үнэ ба борлуулах үнийн харьцуулалт, хувь
1	Үхрийн ястай мах	5640	8490	5750	32,3
2	Хонины ястай мах	4900	7070	5400	23,6
3	Ямааны мах	4000	5305	4400	17,1

4.Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2016 онд 1556,3 тн үхэр, 1494,8 тн хонь, 4688,3 тн адуу, 1216,8 тн ямааны мах тус тус боловсруулсан нь 2015 оныхтой харьцуулахад адуу, өлөн гэдэс, хиаман төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 26-40 хувиар өссөн бол үхэр, хонь, ямааны махны үйлдвэрлэл 45.6-56.0 хувиар тус тус буурсан байна.

5.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2016 онд мал төхөөрөх, мах боловсруулах дараах үйлдвэрүүд шинээр ашиглалтад орж, 200 ажлын байрыг бий болгосон байна. Үүнд:

## Хүснэгт 12

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Хүчин чадал
1	“Жаргалант шанд” ХХК	Ховд	500 бог, 100 бод
2	“Жаргалант мах импекс” ХХК	Орхон	100 бог, 20 бод
3	“Мах март” ХХК	Баянхонгор	500 бог, 50 бод
4	“Хүрийн Овоо” ХХК	Говь-Алтай	1000 бог, 200 бод
5	“Алтайн сүрлэг нуруу” ХХК	Говь-Алтай	250 бог, 100 бод
6	“Баяндэлгэр хүнс” ХХК	Төв/Баяндэлгэр	100 бог, 50 бод
7	“Саян-Уул” ХХК	Улаанбаатар	300 бог, 100 бод

## Дүгнэлт

- ❖ Хөтөлбөрийн үйл ажиллагааны гүйцэтгэл 87.5 хувьтай байна.
- ❖ Хөтөлбөрийн хүрээнд махны үнийг тогтворжуулж, хот суурин газрын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд тогтвортой үнээр мах нийлүүлэх, улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулах нөхцөлийг бүрдүүлж байна.
- ❖ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь малчдаас мал, мах бэлтгэж малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна.

## 1.4.2 Мал аж ахуйн салбар хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүд

**“Монгол мал” үндэсний хөтөлбөр**

**Хөтөлбөрийн товч танилцуулга.** Тус хөтөлбөрийг УИХ-ын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор, хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 222 дугаар тогтоолоор тус тус баталсан. Хөтөлбөрт дэвшүүлэн тавьсан 5 тэргүүлэх чиглэлийг хангах зорилгоор нийт 87 арга хэмжээг тусгасан.

**Хөтөлбөрийн зорилго.** Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах

үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл**

1. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчин бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангаж, сайн засаглалыг хөгжүүлэх;

2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх;

3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;

4. Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйг хөгжүүлэх;

5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.

**Хөтөлбөрийн хүрэх үр дүн.** “Монгол мал” хөтөлбөрийн хоёр дахь үе шат /2016 - 2021 он/-нд дараах үр дүнд хүрнэ:

- ❖ Мал аж ахуйн хөгжлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, урамшууллын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- ❖ Нийт мал сүргийг бүртгэлжүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгож түүнд бүртгэлээр тавих хяналтын тогтолцоог бүрдүүлж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, экспортлох боломжтой болно. Малын удмын санг баяжуулах, хадгалах, хамгаалах, зохистой ашиглах нөхцөл сайжирч, импортыг орлох үржүүлгийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангана;
- ❖ Байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархвар, голомтыг бүртгэн мэдээлэх газар зүйн мэдээллийн систем нэвтэрч, малын эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх сүлжээ бий болж, лабораториудын үйл ажиллагааны чадавхыг сайжруулан, био аюулгүй байдлыг ханган гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэж, бруцеллёзоор тайван орны статусыг хангана;
- ❖ Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлэх хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэн байгалийн эрсдэлд автагдах явдлыг бууруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ;
- ❖ Малын гаралтай түүхий эдийн нөөцийг дотооддоо бүрэн боловсруулж, экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.

### 2016 ОНД ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 13

д/д	Шалгуур үзүүлэлтүүд		Үнэл-гээ (хувь)
<b>1. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.</b>			
1	1.1	Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох	90
2	1.2	Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх	70
3	1.3	Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх	90
<b>Дундаж</b>			<b>83.3</b>
<b>2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх;</b>			
	2.1	Малын чанар, ашиг шимийг сайжруулах	70
4	2.2	Малын удмын санг хамгаалах	90
5	2.3	Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн	50

6	2.4	Оны эхний малын тоо	100
7	2.5	Нэг малаас авах ашиг шим	70
8	2.6	Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох	50
<b>Дундаж</b>			<b>71.6</b>
3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;			
9	3.1	Монгол Улс зарим гоц халдварт өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах	50
10	3.2	Малыг зарим нэрийн өвчнөөс эрүүлжүүлэх	90
11	3.3	Малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх	50
12	3.4	Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхтай болох	70
13	3.5	Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох	70
14	3.6	Малын эм, биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийг дотооддоо үйлдвэрлэх	90
<b>Дундаж</b>			<b>70.0</b>
4. Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйг хөгжүүлэх;			
15	4.1	Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ	70
16	4.2	Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг /квот /тогтоох	10
17	4.3	Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох	10
18	4.4	Бэлчээр сайжруулах арга хэмжээ	70
19	4.5	Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох	50
20	4.6	Бэлтгэх тэжээлийн хэмжээ	90
<b>Дундаж</b>			<b>50.0</b>
5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.			
21	5.1	Мал нядалгааны цех бий болгох	70
22	5.2-5.3	Мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэх махны хэмжээ, нийт үйлдвэрлэх сүүний хэмжээ	50
23	5.4	Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох	90
24	5.5	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох	90
<b>Дундаж</b>			<b>75.0</b>
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>69.9</b>

#### Дүгнэлт

1. “Монгол мал” хөтөлбөрийн эхний үе шат /2010-2015/-нд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтай үнэлэгдсэн ба төлөвлөгөөнөөс 11 арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй удаашралтай байсан, 11 арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй гэсэн үр дүн гарчээ.

2. Хөтөлбөрийн 1 дэх үе шатнаас хэрэгжээгүй үлдсэн арга хэмжээнүүдийг 2016 онд хэрэгжүүлээгүй нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө батлагдаагүйтэй холбоотой байна.

3. Хөтөлбөрийн 2 дахь шатны 2016 оны шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийн үнэлгээ 69.6 хувьтай байна. Үнэлгээ харьцангуй өндөр гарч байгаа нь хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд нь жил бүр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгддэг ажлууд байна.

4. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс “Монгол мал” болон “Хоршоог хөгжүүлэх” хөтөлбөртэй нийцүүлэн төсөл хэрэгжиж буй аймгуудын малчин өрхүүд болон аймаг, сумын төвийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

5. Хөтөлбөрийн “Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйг хөгжүүлэх” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтээр үр дүн, үр нөлөөг

тооцон үнэлэхэд хүндрэлтэй, хөтөлбөрийг олон мэргэжилтэн ээлжлэн хариуцан ажилласан нь хөтөлбөрийн тайлан, арга хэмжээний хэрэгжилт, бодит үр дүнгийн байдлаас харагдаж байна.

6. Энэхүү хөтөлбөрийн нэгдсэн төсөв батлагдаагүй, үйл ажиллагааны зардал тодорхой бус, хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, үнэлгээ хийх, дүгнэлт өгөх ажилд хүндрэл учирч байна. Мөн түүнчлэн аймаг, нийслэлийн түвшинд батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийн үр дүн хөтөлбөрийн үндсэн тайланд тусгагдахгүй өдий хүрчээ.

### **Зөвлөмж**

1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёрдугаар үе шатанд /2016-2021 он/ хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний нэгдсэн төсвийг батлуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний үр дүн, үр нөлөөллийг дүгнэхэд боломжтой байдлаар тайланг бэлтгэхэд анхаарч ажиллах,

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар үе шатны арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хөтөлбөрийн “Удирдах хороо”-гоор батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах,

3. Хөтөлбөрийн эхний шатанд хэрэгжиж дуусаагүй болон хэрэгжээгүй арга хэмжээг хоёрдугаар шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангах,

4. Хөтөлбөрийн “Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйг хөгжүүлэх” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг үр дүн, үр нөлөөг тооцож болохуйц шалгуур үзүүлэлтээр шинэчлэх,

### **1.4.3 Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүд**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор “Чацаргана” үндэсний хөтөлбөрийг батлан жимс, жимсгэний салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, тариалалт, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох арга хэмжээ авч чацаргана болон бусад жимс жимсгэнэ тариалан түүнийг боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан экспортын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилтуудыг дэвшүүлэн тавьсан.

“Чацаргана” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг ХХААХҮ-ийн Сайдын 2010оны А/106 тушаалаар байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2011-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, нийт 19.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсөв, “Чацаргана” хөтөлбөр, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зарцуулаад байна. Тухайлбал:

Дотоодод ургуулсан “Жимс жимсгэнэ”-ийг НӨАТ-аас, жимс жимсгэнэ хураах, боловсруулах тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас 2020 он хүртэл чөлөөлүүлсний зэрэгцээ жимс жимсгэнийн аж ахуй эрхлэгч болон боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогын албан татварыг 2021 он хүртэл 1 хувь болгон бууруулж дэмжлэг үзүүлэв.

Чацаргана, үхрийн нүд, алим, чавга, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, далан хальсны суулгацын стандарт, чацарганы тос, чацарганы жимс, жимсний шүүс, нектарын улсын стандартуудыг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдлөг болгов.

Жимс, жимсгэнийн дотоодын суулгац үржүүлэгчдийг дэмжих, тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2010-2013 онд 5.6 тэрбум төгрөгийн 2.636.0 мянган ширхэг чацарганы суулгац, 60.0 мянган ширхэг гүзээлзгэний суулгацыг дотоодын суулгац үржүүлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авч төсөл сонгон шалгаруулан 22 аймгийн 2000 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 5 жилийн хугацаатай зээлээр олгон жимс жимсгэнийн талбайг 2100 га талбайгаар нэмэгдүүлсэн. Суулгац үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор зориулалтын төхөөрөмж бүхий 75 иж бүрдэл хүлэмжийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосноор жилд 2.6 сая ширхэг суулгац үржүүлэх боломж бүрдүүлэв.

Увс аймагт “Увс хүнс” ХК-д 400.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж жилд 1500 тонн, Улаанбаатар хотод Живэртийн оргил ХХК-ийн “Шар доктор” үйлдвэрт 700.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж жилд 1500 тонн чацаргана боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан ашиглалтад оруулсан ба хувийн хөрөнгө оруулалтаар Витафит ХХК, Тэсо групп ХХК, Хаан жимс эс би Ти ХХК-ийн “Хуба хаяа” зэрэг 20 гаруй жижиг, дунд хүчин чадлын үйлдвэр шинээр ашиглалтад орж жилд 9600 тонн чацаргана, жимс жимсгэнэ боловсруулах хүчин чадал бүхий 52 боловсруулах үйлдвэр бий болоод байна.

Алим, чавга, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, үхрийн нүд зэрэг бага тархацтай, Монголд ургах боломжтой жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд “Жимс жимсгэний аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх” төсөл шалгаруулалт зохион байгуулан 74

иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулан нийт 2.3 тэрбум төгрөгийн жилийн 2.4 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай зээл олгож жимст цэцэрлэгийн талбай 150.0 га-гаар нэмэгдүүлэв.

2014 онд Монгол чацарганын үнэ цэнийг бий болгож, экспортод тогтвортой гаргадаг болох бүтээгдэхүүний чанарт суурилсан, тариалах сорт, ургуулах технологиор төрөлжсөн, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын нэгдсэн өртгийн сүлжээ үүсгэх Монгол чацарганын кластерын тогтолцооны санаачилга төсөл шалгаруулж Хархорин ХК, Эко-Эрдэнэ ХХК, ШУТИС-ын Үйлдвэрлэлийн технологийн сургуультай гэрээ байгуулан 900.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгож технологи шинэчлэх, хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна. Жимсний технологийн шинэчлэлийн хүрээнд 2014 онд 499,9 сая төгрөгийн санхүүжилтээр хуурай уур амьсгалтай орнуудад жимст мод тариалахад зориулсан 210 морины хүчтэй трактор 1 ширхэг, мод суулгах мөр гаргагч 1 ширхэг, жимсний мөр хоорондын хог ургамал устгах хадуур 2 ширхэг, жимсний талбайн хортон шавьжтай тэмцэх хор шүршигч 2 ширхгийг нийлүүлж богино хугацаанд 250 га талбайд жимс, жимсгэнэ тариалах, арчлах ажлыг механикжуулах боломжийг бүрдүүлсэн.

Салбарын хөгжил дэвшилд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээний ололтыг хөгжүүлэх зорилгоор “Жимс жимсгэнийн сорт судалгаа”, “Байгалийн чацарганын тархалт, генетик нөөцийн судалгаа”, “Жимс жимсгэнийн талбайн өвчин хортны тархалт, хөнөөлийн судалгаа”, “Жимс, жимсгэний зах зээлийн нөхцөл байдлын үнэлгээ, кластерээр хөгжүүлэх”, “Чацаргана хураах тоног төхөөрөмжийн судалгаа, туршилт”, “Монгол чацарганыг газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгэлжүүлэх, шинж чанар, найрлагыг тодорхойлох” зэрэг эрдэм, шинжилгээ, судалгааны олон төслүүдийг санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

“Чацаргана” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр жимс жимсгэнэ түүний дотроос чацаргана тариалах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдэж 2016 онд жимс жимсгэнийн талбай 6.07 мянган талбайд хүрч 2009 оноос тариалалт 4516 га-гаар буюу 3.9 дахин, хураасан ургац 2176 тонноор буюу 6.6 дахин нэмэгдэж чацаргана боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортод гаргах түүхий эдийн нөөцтэй болоод байна. Алим, чавга, интоор, гүзээлзгэнэ, чацаргана, үхрийн нүд зэрэг суулгацыг дотооддоо үйлдвэрлэх 34 га талбай бүхий эх цэцэрлэг байгуулж, 2.2 сая ширхэг жимс жимсгэнийн суулгацыг дотооддоо үйлдвэрлэж, 2500 гаруй ногоон ажлын байр бий болгосон байна.

Үүний зэрэгцээ гадаад улсад экспортлох чацарганын бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ жил бүр нэмэгдэж байна. Тухайлбал Сийбэрри ХХК зөөлөн эдийн тос, хатаасан навч, жимсийг БНСУ-д экспортлож гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэн АНУ, БНСУ, Япон, Сингапур, Малайз зэрэг 6 оронд борлуулж байна. Увс хүнс ХК үрийн болон зөөлөн эдийн чацарганы тосыг БНСУ, АНУ, Тайвань улсад гаргаж эхэлсэн бол, Живэртгийн оргил ХХК Япон улс руу тос, шүүс, Витафит ХХК Япон, Солонгос улсад чацаргана, нэрсний шүүс экспортолж эхлээд байна.

#### **1.4.4 Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд**

**Монгол Улсыг Үйлдвэржүүлэх хөтөлбөр.** Уг хөтөлбөр 2009-2016 онд хэрэгжиж дууссан байна. Хөтөлбөр 2009 онд батлагдсан үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох талаар алсыг харсан оновчтой олон хууль боловсруулан хэрэгжүүлэхээр тусгажээ. Тухайлбал: Хөтөлбөрт нийт 9 хуулийг шинээр боловсруулан батлуулахаар тусгагдсанаас (*бирж, зээлийн баталгаа, хөрөнгө оруулалтын сан, даатгалын сан гэх мэт*) 8-н хуулийг батлуулсан, нэг хууль боловсруулах шатандаа, 8 (*Хүнсний, Ашигт малтмал, инноваци, технологи дамжуулах тухай, концессийн, ЖДҮД, санхүүгийн түрээс, хөдөлмөрийн тухай*)-хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгагдсанаас 5 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан, мөн эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд НӨАТ, гаалийн татвар, гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх зэрэг олон жижиг дагалдах хуулийг тухай бүр батлан хэрэгжүүлж үйлдвэр хөгжүүлэхэд тодорхой үр дүнд хүрсэн байна. Хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол улсад олон үйлдвэр шинээр бий болж, үйлдвэрлэлээ өргөтгөж, шинэ техник технологи нэвтрүүлсэн, олон хүнийг ажлын байраар хангасан байна.

Үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох чиглэлээр, Хөгжлийн банк, Чингис бонд, тусгай сангуудын хүрээнд иргэн, аж ахуй нэгжүүд хөнгөлөлттэй зээлэнд хангалттай хамрагдсан боловч гарсан үр дүн ажлын байр нэмэгдсэн, үйлдвэрлэлээ өргөтгөсөн, шинээр ажлын байр бий болсон зэргээр хязгаарлагдаж байгаагаас зээл тусламжийн хүрээнд нэвтрүүлсэн шинэ техник, технологи, лизингээр авсан шинэ тоног төхөөрөмж, тэдгээрийн ашиглалт, бүтээмж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шалгуур үзүүлэлттэй уялдуулан үнэлэх боломжгүй байна.

Цахим мэдээллийн сан, аутсорсинг, технологи дамжуулах төв, инкубаци, үйлдвэр технологийн парк, кластер зэрэг асуудалтай холбоотой заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

**Хэвлэлийн Үйлдвэрлэл хөтөлбөр.** Хөтөлбөрийг 2008-2016 хэрэгжих үеийн суурь түвшингийн үзүүлэлтээс харахад цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2007 онд 3127,6 сая төгрөг байсан бол, хэрэгжиж дуусах үе буюу 2016 оны цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15630,0 сая төгрөг болж даруй 5 дахин нэмэгдсэн байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын тоо 2007 онд 1800-2000 орчим байсан бол, 2016 оны эцсээр 4000 орчим болж өссөн, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсадтай харьцуулахад хэвлэлийн үйлдвэрийн ажиллагсдын эзлэх хувь нь 7.8-11.8 хувиар өссөн дүнтэй байна.

Аж ахуйн нэгж байгууллагуудын идэвх санаачлага, хичээнгүй хөдөлмөрийн үр дүнд хэвлэлийн салбарын техник технологийн түвшин олон улсын жишигт тодорхой хэмжээгээр хүрсэн гэж үзэж болохоор байна.

Хэвлэлийн үйлдвэрүүдийн 90 хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгааг анхааралдаа авч Үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэвлэл, сав баглаа боодлын үйлдвэрүүдийг нэгтгэн хорших, төрөлжихөд төрөөс дэмжлэг үзүүлбэл цаашид эрчимтэй хөгжих нөхцөл бүрдсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 удаагийн төлөвлөгөөнд тусгагдсан Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтийн дөнгөж 15.6 хувийг олгосон нь хөтөлбөрийн зорилтод арга хэмжээ бүрэн хэрэгжихэд нөлөөлсөн гэж үзэж байна.

Хэвлэлийн будаг, бодис болон бусад туслах материалын үйлдвэрлэл байгуулах, хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтыг сайжруулах лаборатори байгуулах, техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох, нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх зохион байгуулалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

Цаашид тус хөтөлбөрийн дутуу болон хэрэгжээгүй боловч зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг шаардагдах төсөв хөрөнгийг гаргуулах асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч, Үйлдвэржүүлэх 21/100 хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

**Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр.** Энэ хөтөлбөр 2008-2017 он хүртэл хэрэгжихээр төлөвлөгдсөн ба хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Хөтөлбөр хэрэгжсэнээр хоршоо байгуулах оролцогчдын идэвх санаачлага нэмэгдэж хоршоодын тоо, гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь өссөн байна.

- Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан сургалт болон гадаад, дотоодын Олон улсын байгууллагын сургалт, арга хэмжээ, хуралд хангалттай сайн хамрагдсан боловч түүний үр дүнд нэвтрүүлсэн шинэ санаа санаачилга, технологи, гарсан үр дүнгийн талаар мэдээлэл бага байна.

- Хөтөлбөрийн зорилтод арга хэмжээнд аймаг тус бүр дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэх талаар тусгасан бөгөөд энэ талаар тайланд мэдээлэл бага, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах талаар дутагдалтай байгаа зэргийг анхаарч цаашид төгсгөлийн /2017он/ шатны тайланд бүрэн тусгаж ажиллах шаардлагатай.

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэх явцад зарцуулсан санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй уялдуулан гаргаж тодорхой судалгаа гарган тайлагнах талаар зөвлөмж гаргасан байна.

**Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр.** Хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөгжлийн банк, Чингис бонд болон тусгай сангуудын хүрээнд маш олон хөнгөлөлттэй зээлд хамрагдаж үйлдвэрлэлээ өргөтгөх, шинээр байгуулах, ажлын нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрсэн байна.

- Иргэн, аж ахуй нэгжүүд хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан боловч гарсан үр дүн ажлын байр нэмэгдсэн, үйлдвэрлэлээ өргөтгөсөн, шинээр ажлын байр бий болсон зэргээр хязгаарлагдаж бүтээмж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл бага байна.

- Тус хөтөлбөрийг бусад тус салбарт хэрэгжсэн хөтөлбөрүүдтэй уялдуулан тайлагнах талаар хангалтгүй ажиллажээ.

- Зээл тусламжийн хүрээнд бий болсон техник, технологи, лизингээр авсан шинэ тоног төхөөрөмжийн талаар мэдээлэл хомс, цахим мэдээллийн сан, аутсорсинг, технологи дамжуулах төв, инкубаци, парк зэрэг асуудалтай холбоотой заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

**“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх” хөтөлбөр.** Хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлэхээр заасан. Тухайлбал:

- Монгол Улсын 21 аймгийн хэмжээнд 67 сумдад 67 “Ахуйн үйлчилгээний төв” шинээр бий болж 66 сумын төвийн 66-н “Ахуйн үйлчилгээний төв”-ийн барилгыг засварлан шинэчилж үйл ажиллагаа эрхлэх тав тухтай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх нэгдсэн төвтэй болгосон

байна. Нийт 164 сумын ахуйн үйлчилгээний төвд хөрөнгө оруулалт хийж одоогоор нийт 221 төв үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд нийт 3444 ажлын байр шинээр бий болж 431 ажлын байр сургалт семинарын явцад 3013 ажлын байр ЖДҮХСан, Сум хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан болон бусад хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон байна. Хөтөлбөрийн санхүүжилтэд төсөвлөсөн 12.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас тодорхой бус шалтгаанаар 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүйгээс болж 109 сумдад шинээр болон засварлан шинэчлэх 109 ахуйн үйлчилгээний төвийг барьж байгуулах ажил хийгдээгүй байна.

#### **Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар нийтлэг дутагдал**

- Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын асуудал Засгийн газрын бүтцийн өөрчлөлт болгонд өөр өөр яаманд харьяалагдаж байсан нь хийсэн ажил үнэгүйдэх, мэдээлэл нь олдохгүй байх зэргээс шалтгаалан маш олон тооны ажлын үр дүн тайланд бүрэн тусгагдаж чадахгүй, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн түвшинд үнэлгээ хийх боломжгүй байна.

- Аймаг, орон нутагт хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажлын талаар орон нутгийн байгууллагатай харилцан уялдаатай ажиллаж ажлаа тайлагнах болон хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон техник, технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл, судалгаа дутагдалтай байна.

### **1.5 Улсын төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт**

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хандивлагч орнууд болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн хүрээнд 11 төсөл хэрэгжиж байгаа ба 2015 оны хэрэгжилтийн гүйцэтгэл дунджаар **84.9** хувийн дүнтэй байна. Энэ нь өнгөрсөн оны түвшнээс 4.9 пунктээр өссөн үзүүлэлт юм.

#### **ГАДААД ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГГИЖ БҮЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ (2016 оны жилийн эцсийн байдлаар)**

Хүснэгт 15

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хэрэгжих хугацаа	Хяналтад авсан заалт	Тухайн жилд хийсэн ажлын үнэлгээ (%)
<b>Хүнсний салбар</b>				
1	“Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” ТСР/MON/3501 техник туслалцааны төсөл	2014-2016	4/11	85.0
2	“Монголын Органик ХАА-г дэмжих” ТСР/MON/3503 техник туслалцааны төсөл /НҮБ-ын ХХААБ	2014-2016	4/18	64.0
<b>Мал аж ахуй, мал эмнэлгийн салбар</b>				
3	“Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага /ШХА/	2013-2016	4/14	91.7
4	“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент”	2011-2016	8/48	89.1
5	“Хөдөө аж ахуйн маркетинг”	2012-2017		86.4
6	“Малын эрүүл мэнд” төсөл (ШХА)	2012-2016	3/8	90.0
7	“Өмнөд өмнөдийн хамтын ажиллагаа (ӨӨХА) хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг дэмжих техник туслалцаа” GCP/MON/010/CPR төсөл	2014-2016	7	100.0
<b>Газар тариалангийн салбар</b>				
8	“Монгол улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төсөл ХБНГУ-ын ХХААЯ	2013-2016	2/4/	94.4
9	“Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх” төсөл (КОПИА)	2014-2017	2/6/	100.0
10	“Монгол ногоо” төсөл	2016-2019		66.0
Дүн				<b>86.66</b>

#### **1.5.1 Хүнсний салбар дахь төслүүд**

**Хүнсний салбарт** хүн амын хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж, баталгаат байдлыг сайжруулах чиглэлээр 2 төсөл хэрэгжиж байгаа ба 2015 оны хэрэгжилт дунджаар 74.5 хувьтай байна.



**“Монголын органик хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх”** төсөл 2014 оны 10 сард нээлтээ хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 оны жилийн эцсийн байдлаар үр дүнгийн биелэлт **64.0** хувьтай байна. Төслийн хүрээнд эх орны байгальд ээлтэй, газар тариалангийн аж ахуйн өнөөгийн байдлын судалгаа, хэрэглэгчийн судалгаа, Япон, БНСУ-ын органик хүнсний зах зээлийн судалгааг баримтын болон анхдагч эх үүсвэрийн аргад тулгуурлан анх удаа явуулсан. Судалгааны дүн болон үйлдвэрлэгч, холбогдох байгууллагын хүсэлтийг үндэслэн чацаргана, зөгийн бал, төмс үйлдвэрлэгч 4 компанийг загвар органик аж ахуй болгохоор сонгон, гэрээ байгуулан ажиллаж байна. СХЗГ-тай хамтран Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын шинжээчийг бэлтгэх танхимын болон үзүүлэх сургалтыг зохион байгуулж, органик хүнсний баталгаажуулалтын чиглэлээр орон тооны бус шинжээчийн эрхийг 25 ажилтанд олгосон нь органик хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх суурийг тавьж, чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна. Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад талууд хамтран баталгаажуулах тогтолцоо /PGS/-ны анхны загварын төслийг бий болгосон.

Органик хүнс, түүний баталгаажуулалтын талаар ойлголт өгөх 12 сургалт хийж нийт 700 хүнийг хамруулсан ба гарын авлага, сурталчилгааны материалыг бэлтгэн органик хүнсний тухай ойлголт мэдлэгийг түгээхэд анхаарч ажиллаж байна.

**“Загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх”** төслийн хүрээнд 2016 онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл **85.0** хувьтай байна.

**Төслийн зорилго** Загасны туршилтын аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж Монгол улсын хүн амын хүнсний хэрэгцээнд биологийн төгс тэжээллэг чанартай загас, загасан бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, Монгол улсад загасны салбар хөгжих тааламжтай орчинг бүрдүүлэх үндсэн чадавхийг бий болгох;

Төслийн санхүүжилтийн гүйцэтгэл

Хүснэгт 16

Он	Зарцуулсан төсөв, ам доллар	Хувь
2014 он	118 104	44.1
2015 он	48 470	18.1
2016 он	101 426	37.8
Дүн	268 000	100.0

**Төслийн зорилтын хэрэгжилт, үр дүн.** Төсөл хамтран хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж болох “Хилэм ост” ХХК, Туул голын сав дагуу Улаанбаатар хотоос доош 43 км зайд байрлах газарт /загасны аж ахуй хөгжүүлэх, загас үржүүлэх/ ажлын зураг, төслийн дагуу битүү дээвэртэй 500м<sup>2</sup> талбайтай барилга барьж байгуулсан байна. Барилгын дулааны асуудлыг шийдвэрлэхээр 800м<sup>2</sup> талбайг халаах хүчин чадалтай халаалтын төхөөрөмжийг Унгар улсаас захиалан авсан байна. Мөн загасны аж ахуйд 2 эгнээ, эгнээ бүр 6 торон хашаанаас бүрдэх, нийт 12 торон хашаа бүхий гадна цөөрмийн усан сан байгуулсан. “Жижиг горхи” /Туул голын сав дагуу Улаанбаатар хотоос дээш 65 км/ аж ахуйд загас үржүүлгийн барилгын зураг төслийн дагуу 500м<sup>2</sup> талбайтай барилга барьж байгуулжээ. ХААИС-д загасны аж ахуйн хүрээлэн буй орчныг хянах, загасны өвчин эмгэгийг оношлох загас судлах зорилго бүхий цэвэр усны эх үүсвэр бүхий 150 м<sup>2</sup> лаборатори байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмол болсон байна. Төслийн хүрээнд нийт 60,000 ам. долларын өртөг бүхий лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулах ажлыг хийж байна.

#### Дүгнэлт

1. Монгол оронд хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан үйлдвэрийн аргаар боловсруулсан загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, загасны аж ахуй хөгжих үндсийг тавьж, үйл ажиллагааг эхлүүлсэнд оршино.

2. Загасны аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх, байгууллагын болон хүний нөөцийн чадавх бүрдүүлэхэд төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа чухал /загасны аж ахуйн технологийн дадлага/ нөлөө үзүүлж байна.

3. Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл нь 85.0 хувьтай.

#### Зөвлөмж

Төслийн хүрээнд тоног төхөөрөмж, туршлага дамжуулж авсан, хүний нөөц нь чадавхажсан сургууль болон аж ахуйн нэгжүүд загас судлал ба үйлдвэрлэл, цөөрмийн аж ахуйн үйл

ажиллагаагаа өргөтгөх, зах зээлд бүтээгдэхүүнээ бодитоор нийлүүлж эхлэх шаардлагатай болсныг зөвлөж байгаа юм.

### 1.5.2 Мал аж ахуйн салбар дахь төслүүд

#### “Малын эрүүл мэнд” төсөл

**Төслийн зорилго.** Малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах, түүнийг илүү үр дүнтэй болгоход хувь нэмэр оруулах.

**Төслийн хэрэгжих хугацаа, нийт санхүүжилт.** Төсөл 2012-2016 онд хэрэгжиж дууссан байна. Төслийн санхүүжилт 5.9 сая Швейцар франк болсон.

Хүснэгт 17

Бүрэлдэхүүн хэсэг	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-1. Бодлого ба хууль эрх зүй	140000	250000	230000	110000	730000
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-2. Өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх	620000	980000	880000	620000	3100000
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-3. Мал эмнэлгийн албан сургалт	210000	160000	260000	290000	920000
Төслийн зохицуулах нэгж	230000	310000	310000	340000	1190000
Нийт	1200000	1700000	1680000	1360000	5940000

#### *Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1. Бодлого ба хууль эрх зүй*

Зорилт 1. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (ДАЭМБ)-ын стандартын (Мал эмнэлгийн албаны гүйцэтгэлийг үнэлэх гарын авлага) дагуу шинэчлэх, техникийн болон зохион байгуулалтын чадавхыг дээшлүүлэх замаар мал эмнэлгийн төвийн болон орон нутгийн байгууллагуудыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах

#### *Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2. Өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх*

Зорилт 2. Өвчинтэй тэмцэх стратегиудыг хэрэгжүүлэх, бүх түвшинд техникийн талын мэдлэгийг дээшлүүлэх замаар бруцеллэз, шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

#### *Төслийн бүрэлдэхүүн хэсэг-3. Мал эмнэлгийн албан сургалт*

Зорилт 3. Төрийн болон хувийн мал эмнэлгийн үйлчилгээний шаардлагад үндэслэн сургалтын хөтөлбөрийг эргэж харах, багш нарыг сургах замаар их сургуулийн түвшинд малын эмчийн боловсрол олгох сургалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах

**Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн.** Төсөл хэрэгжүүлэхдээ аль нэг аймаг, сумыг тусгайлан сонгоогүй бөгөөд үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна. Малын өвчнийг хянах бодлогын гол асуудлыг хуульчлах, халдварт өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж, хэрэгжүүлэх, өвчний тархалтыг зогсоох, хяналтад авах үйл ажиллагааг үнэлэх, хянах механизмыг бий болгоход төсөл чухал хувь нэмэр оруулсан байна. Түүнчлэн чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны элементүүдэд зорилтот хүрээний шийдвэр гаргагчид, Засгийн газрын байгууллагуудын албан хаагчид, мал эмнэлгийн бүх шатны байгууллагын мэргэжилтэн, ажилтан, техникийн ажилтан болон багшлах боловсон хүчин хамрагджээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл боловруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэн ажилласны дүнд тус хуулийн төсөл 2017 оны хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороод байна. Үүнээс гадна Шүлхий өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги /2014-2018 он/ болон Бэлэн байдлын үндэсний төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 25-ны А/112 тоот тушаалаар баталсан эдгээр баримт бичгийг ДАЭМБ-ын Ерөнхий чуулганаас хүлээн зөвшөөрч 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батламжиллаа. Ийнхүү Монгол улс Шүлхийтэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө албан ёсоор батлуулсан ДАЭМБ-ын 9 дэх гишүүн, Ази-Номхон далайн бүсийн 3 дах орон болов. Энэ бол Монгол улсын шүлхийтэй тэмцэх арга хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрсний илэрхийлэл юм.

Мөн малын бруцеллэстэй тэмцэх стратеги, төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Малын бруцеллэстэй тэмцэх стратеги, төлөвлөгөөг ХХАА-н сайдын 2015 оны А-154 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна. УМЭАЦТЛ-ийг түшиглэн Малын бруцеллэзын үндэсний лавлагаа лаборатори байгуулахад төслөөс 200.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Мөн мал эмнэлгийн лабораторийн цахим бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинээр бүрдүүлж, програм хангамжийг нэвтрүүлэн, нэгдсэн сан байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Малын эрүүл мэнд төслөөс УМЭАЦТЛ-ийн оношилгоонд зориулсан

орчин үеийн эд задлагч, оношлуур, урвалж, хэрэглэгдэхүүн нийлүүлсний үр дүнд шүлхий өвчнийг өмнө нь 72 цагт оношилдог байсан бол одоо 6 цагт багтаан оношлох бүрэн боломжтой болжээ.

Нийслэлийн мал эмнэлгийн газарт 16.0 сая төгрөгөөр нян өсгөвөрлөх CO2 инкубатор, УМЭАЦГЛ-ийн задлангийн өрөөнд 11.5 төгрөгөөр, Гоц халдварт өвчний оношилгоо тандалтын тасагт 50.0 сая төгрөгөөр нэн шаардлагатай багаж хэрэгсэл, Мал эмнэлгийн хүрээлэнд 14.0 сая төгрөгөөр бруцеллёзын өсгөвөр, ийлдэс хадгалах гүн хөлдөөгч худалдан авч өгч хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүний зэрэгцээгээр Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх, гаралт, тархалтыг бууруулах; шуурхай хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, мал эмнэлгийн салбарын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах зорилго бүхий Шуурхай хариу арга хэмжээний төвийг МЭҮГ-т байгуулж 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

Малын эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тавигдаж байгаа хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн Лондонгийн их сургуулийн Хатан хааны мал эмнэлгийн сургуулийн хөтөлбөртэй дүйцүүлэн шинэчилж 2015/2016 оны хичээлийн жилээс мөрдөгдөж эхэлжээ. Мөн МЭС-ийн Клиник сургалтын байгууламжийн барилгыг 100.0 сая төгрөгөөр төслөөс санхүүжүүлэн барьсан байна. Үүнээс гадна орчин үеийн шаардлагад нийцсэн номын сан, лекцийн тэнхимийг 120.0 сая төгрөгөөр байгуулсан байна. МЭС-ийн цахим хуудас - интранетийг хийж, багш нар өөрийн хичээл, танилцуулгуудыг оюутнуудтайгаа хуваалцах боломжийг олгожээ. Сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүдэд нийт 11 зөөврийн компютерийг олгосны зэрэгцээ Клиник ур чадварыг хөгжүүлэх төвийг байгуулахад 110.0 сая төгрөгийн, задлан шинжилгээний хичээлд зориулж 11.5 сая төгрөгийн, санал хураах 80 ширхэг төхөөрөмж авахад зориулж 11.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

**Үнэлгээ.** Төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ төсөл хэрэгжсэнээс хойших үр дүнгийн үнэлгээг өссөн дүнгээр тооцсоноос гадна үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтээр тооцож хувиар илэрхийлэн гаргалаа.

Хүснэгт 18

д/д	Үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1	Төсөл хэрэгжсэнээс хойших үр дүнгийн үнэлгээ, хувиар	23.3	50.0	75.0	=	90.0
2	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ, хувиар	84.2	86.6	80.0	84.4	86.0

### Дүгнэлт

1. Малын эрүүл мэнд төслийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 86.0 хувь байна. Харин төслийн үр дүнг төсөл хэрэгжсэнээс хойших хугацааны өссөн дүнгээр тооцож үзэхэд 90.0 хувь буюу “хангалттай сайн” үнэлгээтэй байна.

2. Тайлант хугацаанд УИХ-ын сонгуулийн жил таарсантай холбоотойгоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаан, УИХ-ын чуулганаар хэлэлцэх үйл явц удааширч төслийн баримт бичгийн 1.2.-т тусгагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах техник ур чадварыг бэхжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт 60.0 хувь буюу “хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

3. Малын эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тавигдаж байгаа хэрэгцээнд нийцүүлж, төгсөгчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвартай уялдуулан шинэчлэх үйл ажиллагаа болон Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай материалын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа “хангалттай сайн” хэрэгжсэн бөгөөд цаашид төслийн үр дүн тогтвортой хадгалагдах боломж бүрдсэн байна.

### “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл

**Төслийн тухай.** Монгол улсын засгийн газар, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд байгуулсан төслийн Санхүүжилтийн гэрээний дагуу “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн үйл ажиллагаа 2011 оны 12 сараас хэрэгжиж эхэлсэн. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл нь НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээл, Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжаар Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Говь-Алтай аймгийн сонгогдсон нийт 89 суманд хэрэгжсэн.

**Төслийн зорилго.** Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх чиглэлээр Монгол улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (IFAD)-аас тавьсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

**Төслийн зорилт.** Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Монгол мал хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр”-тэй нийцүүлэн төсөл хэрэгжиж буй аймгуудын малчин өрхүүд болон аймаг, сумын төвийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж ядуурлыг бууруулах. Төсөл дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ❖ *Бэлчээрийн менежмент ба байгаль, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь*
- ❖ *Зах зээлийн хөгжил*
- ❖ *Төслийн менежмент ба бодлогын дэмжлэг*

**Төслийн нийт төсөв.** Нийт төсөв 13.0 сая ам. доллар, үүнээс 11.5 сая ам.доллар нь ХААХОУС-ийн хөнгөлөлттэй зээл, 1.5 сая ам. доллар нь Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгө байна.

**Төсөл хэрэгжих хугацаа.** Энэхүү төслийн ажил 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үргэлжилж байгаа тул үнэлгээний ажлыг 2016 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хийж гүйцэтгэсэн. Иймээс энэ оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийсэн ажлын тайланг санхүүгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын хамт бэлтгэж 2017 оны 04 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг, мөн түүнчлэн төслийн зүгээс аймаг, орон нутаг, хамтран ажилласан байгууллагатай байгуулсан төслийн ажлын гүйцэтгэл, хяналт тавих тухай гэрээнүүдийн биелэлтийг эцсийн байдлаар дүгнэж тайланд хавсаргах шаардлагатай байгаа юм.

**Төслийн санхүүжилт болон хэрэгжилт.** Төслийн санхүүжилтийг 2016 оны эцсийн байдлаар авч үзвэл ХААХОУ-ын сангийн хөнгөлөлттэй зээлийн 75.8 хувь буюу 8,464,054.0 ам.доллар, ДДБОС-ийн буцалтгүй тусламжийн 80.3 хувь буюу 1,204,747.9 ам.доллар, нийт **9,668,802 ам доллар** зарцуулагдсан байна.

**Төслийн гол үр дүн.** Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт.

Хүснэгт 19

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин	Хувь
Зорилт 1. Бэлчээрийн менежмент ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь	<b>Зорилт 1.1. Бэлчээрийн менежментийн орон нутгийн байгууллагыг байгуулж, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулна.</b>		
	120 малчны бүлэгт 3600 малчин өрх хамрагдаж БМТөлөвлөгөө боловсруулна.	2835 өрх бүхий 120 малчны бүлэг байгуулагдсан	100
	Бүлгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо 30 хувь байна.	Бүлгийн зээл батлах хорооны гишүүний 101 буюу 40 хувь нь эмэгтэй.	100
	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний 80 хувь нь хэрэгжсэн байна.	Байгуулагдсан 120 бүлэгт 20 төрлийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна.	100
	<b>Зорилт 1.2. Малчид, орон нутгийн удирдлагын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар мэдлэг сайжирч, малчин өрхүүдийн байгаль цаг, уурын бэрхшээлийг даван туулах чадавхи нэмэгдэнэ.</b>		
	600 Малчин өрхийг малын индексжүүлсэн даатгалын сургалтад хамруулна	1750 Малчин өрхийг малын индексжүүлсэн даатгалын сургалтад хамруулсан	100
	30 хүнийг худаг засварчны сургалтад хамруулна	32 хүнийг хамруулсан	100
	30 ядуу малчин өрхийн гишүүнийг мэргэжил олгох сургалтад хамруулна	83 ядуу малчин өрхийн гишүүнийг мэргэжил олгох сургалтад хамруулсан	100
	15 суманд цаг уурын мэдээ хүргэх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ	15 суманд цаг уурын мэдээ хүргэх мобигатер олгосон	100
	12 суманд цаг уурын автомат станц нийлүүлнэ	Төслийн санхүүжилтээр 7 суманд улсын төсвийн хөрөнгөөр 5 суманд суурилуулсан	100
	Сумдын цаг уурын станцад дэмжлэг үзүүлнэ	5 сумын цаг уурын станц, өртөө харуулын хашаа барих ажлын байртай болоход дэмжлэг үзүүлсэн	100
	<b>Зорилт 1.3. Малчдын байгаль, цаг уурын бэрхшээлийн даван чиглэлээр бүлгийн төлөвлөгөө, орон нутгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөрөнгө оруулалтуудыг хийнэ.</b>		
	46 худаг шинээр гаргах	64, худаг шинээр гаргаж 16 гүн өрмийн худаг засварласан	100
	5 Өвсний саравч, тэжээлийн агуулах барих	16-ыг шинээр барьж 2-ыг засварласан	100
	Малчны бүлгийн гишүүдийн 50 хувь нь бэлчээрийн менежментийн сургалтад хамрагдана	2475 (87 хувь) хүн бэлчээрийн менежментийн сургалтад хамрагдсан.	100
	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сургалтыг төслийн 15 суманд хийж гүйцэтгэнэ.	5 аймгийн төв, 15 суманд зохион байгуулж 732 хүнийг хамруулсан	100

	600 Малчин өрхийг мал эмнэлэг үржлийн сургалтад хамруулна	584 хүнийг мал эмнэлэг үржлийн сургалтад хамруулсан	97
	100 Булгийн эх хашиж, хамгаалах	93 булгийн эх хашсан	93
	120 Бага оврын трактор олгох	120 бага оврын трактор малчны бүлгүүдэд олгосон	100
	100 Хадлангийн талбай хаших	53 хадлангийн талбай хашсанаас гадна, төслийн 12 суманд өссөн дүнгээр 70000 га хадлангийн талбай хамгаалалтад авсан	52
	15 суманд цаг уурын автомат станц нийлүүлэх	Цаг уур орчны шинжилгээний хүрээлэнтэй байгуулсан гэрээний дагуу төслийн хөрөнгө оруулалтаар 8 суманд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 суманд автомат станцыг суурилуулсан.	100
	100 Бороожуулагч	33 бороожуулагчийг хэрэгцээтэй малчны бүлгүүдэд олгож, 19-ийг хүнсний ногоо тариалдаг хэрэгцээтэй эмэгтэйчүүдийн бүлгүүдэд олгосон. (Санхүүжүүлэгч байгууллагын зөвлөмжийн дагуу энэ хөрөнгө оруулалтыг зогсоосон)	53
	30 Нарны цахилгаан үүсгүүр	30	100
	5 ус цуглуулах хөв барих	10	100
	Загвар өвөлжөө, хаваржаа барих	19 суманд өвөлжөө, хаваржаа барьж, 4 аймгийн цөм сүргийн үржлийн төвд зөөврийн хашаа 6 ширхгийг олгосон	100
	15 суманд сургалт мэдээллийн өрөө тохижуулах	15 суманд сургалт мэдээллийн өрөөг засаж тохижуулан шаардлагатай сумдад сургалтын ширээ сандал, компьютер, телевизор зэргийг олгосон.	100
	15 суманд бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажил зохион байгуулна	2014-2015 онд 14 суманд хортон мэрэгчтэй тэмцэх ажлын зохион байгуулж, 2016 онд 35 утагч төхөөрөмж сумдад олгосон	100
<b>Зорилт 1-ийн дундаж хувь</b>			<b>95.66</b>
<b>Зорилт 2. Зах зээлийн хөгжил бүрэлдэхүүн хэсэг</b>	<b>Зорилт 2.1. Хамтын харилцаага хүлээсэн эмэгтэйчүүд давамгайлсан бүлгийн гишүүд нь бичил зээлийг ашиглан бизнесээ өргөжүүлнэ.</b>		
	3280 хүн 410 эмэгтэйчүүдийн бүлэгт хамрагдаж үйл ажиллагаагаа хэвийн явуулна.	3664 гишүүн бүхий 455 эмэгтэйчүүдийн бүлэг байгуулагдсан.	100
	Байгуулагдсан бүлгийн 70 хувь (287) банк болон бусад эх үүсвэрээс зээл авсан байна.	Байгуулагдсан 476 бүлгийн 86.3% буюу 393 нь зээл авсан.	100
	<b>Зорилт 2.2. 3280 хүн өөрсдийн орлогоосоо хадгаламж хуримтлуулах, банкнаас болон бусад албан ёсны эх үүсвэрээс зээл авах тал дээр эмэгтэйчүүдийн мэдлэг чадвар дээшилсэн байна.</b>		
	Байгуулагдсан бүлгийн 60 хувь (246) хуримтлал хийсэн байна.	Байгуулагдсан 390 бүлэг хуримтлалын дундын сантай болсон.	100
		Өссөн дүнгээр 7700 гаран хүн, бичил бизнес, банк санхүү, бүлгийн менежмент, хоршоо, технологийн сургалтууд хамрагдсан.	
	<b>Зорилт 2.3. Зээлийн батлан даалтын дэмжлэгтэйгээр ядуу орлого, багатай иргэдэд хүрэх зээлийн хүртээмж сайжирна.</b>		
Оролцогч санхүүгийн байгууллагын тоо	8 Банктай батлан даалтын гэрээ, /Капитал, Төрийн банктай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан	100	
Зээлдэгчид /гаргасан батлан даалтын / тоо	362 бүлэгт 3,284,300,000 сая төгрөг, (164,8 сая төгрөгийн зээлийг ХЭДСангаас олгосон), төслийн аж ахуйн нэгжийн хувьд Жайкагийн “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээл”-ийн төслөөс нийт 6 аж ахуйн нэгжид 1.156 сая төгрөгийн, тус төсөл өөрийн эх үүсвэрээс нийт 9 аж ахуйн нэгжид 693.5 сая төгрөгийн санхүүжилт, нийт 15 аж ахуйн нэгжид 1.8 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосон	100	

	Олгосон зээлийн хэмжээ	1023 (2016 эцсийн байдлаар эмэгтэйчүүдийн бүлгийн зээлийн хүрээнд байгуулсан Багцын батлан даалтын гэрээний дагуу Төрийн банкны Капитал банкны нийт 334 зээлд 2,308,873.3 мянган төгрөгийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлийн хүрээнд байгуулсан Багцын батлан даалтын гэрээний дагуу нийт 675 зээлд 1,386,294.2 мянган төгрөгийн, хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Ганцаарчилсан батлан даалтын гэрээний дагуу Хас банкны 3 зээлд 247,000.0 мянган төгрөгийн, Капитал банкны 1 зээлд 80,000.0 мянган төгрөгийн, Голомт банкны 1 зээлд 35,000.0 мянган төгрөгийн, Төрийн банкны 9 зээлд 328,300.0 мянган төгрөгийн, нийт 15 зээлд 963,600.0 мянган төгрөгийн, <b>нийтдээ 4,800,786.0 мянган төгрөгийн батлан даалтыг 1023 зээлдэгчид сарган ажиллалаа.</b>	100
	Үр дүнгийн хүрээнд: Зээл авсан иргэдийн 50 хувь нь бизнесийн зээл байна.	Төслийн үр шим хүртэгч өрхийн 40 хувь нь бизнесийн буюу орлого бий болгох үйл ажиллагаа, 21 хувь хэрэглээний зээл байгаа бол, үр шим хүртэгч бус өрхийн 42 хувь нь хэрэглээний зээл, 26 хувь хувь бусад хөрөнгө оруулалтын зээл байна. /ҮДС/	80
	45 Жижиг, дунд үйлдвэр, хоршоог дэмжинэ.	55 аж ахуйн нэгжийг сонгон чадавхжуулах сургалтад хамруулсан.	100
	Жижиг дунд үйлдвэр, хоршоодын бизнес төлөвлөгөөний доод тал нь 80 хувь банкны шаардлагыг хангасан байна.	Сонгогдсон 55 аж ахуйн нэгж 100 хувь зээлийн төсөл боловсруулж банканд хандаад байгаа ба 18 нь зээл аваад байна.	37
	Үндэсний хэмжээний 3 нэмүү өртгийн сүлжээг дэмжих чиглэлээр ханган нийлүүлэгчдийг сургалтад хамруулна.	Сүү, 2.Чацаргана 3 байцаа, хүнсний ногоо чиглэлээр 730 хүнийг сургалтад хамруулсан	100
	<b>Зорилт 2-ийн дундаж хувь</b>		91.7
<b>Зорилт 3. Төслийн үйл ажиллагаа нь цаг хугацаандаа, өртөг хэмнэж зорилтод бүлэгт хүрч үйлчилнэ.</b>			
	3.1. Үр шим хүртэгсдийн 70 хувь нь төслийн ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагдсан байна.	Үр дүнгийн судалгаагаар үр шим хүртэгч өрхийн 87 хувь нь дор хаяж төслийн нэг үйл ажиллагаанд хамрагдсан гэж хариулжээ.	80
	3.2. Үр шим хүртэгсдийн дунд ядуу болон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Төслийн нийт үйл ажиллагаанд хамрагдсан хүний дунджаар 61 хувь эмэгтэй байна. Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүдийн 28 хувь, малчны бүлгийн гишүүдийн 27 хувь ядуу, нэн ядуу иргэд байна.	80
	<b>Зорилт 3 дундаж хувь</b>		80
<b>Ерөнхий дундаж хувь</b>			<b>89.1</b>

### Дүгнэлт

1.Төслийн санхүүжилтийг 2016 оны 12 сарын эцсийн байдлаар авч үзвэл, төсөлд зарцуулахаар төлөвлөсөн 12,785,714 ам.долларын 75.6 хувь буюу 9,668,802 ам.долларыг, үүнээс ХААХОУ-ын сангийн хөнгөлөлттэй зээлийн 75.8 хувь буюу 8,464,054.0 ам.доллар, ДДБОС-ийн буцалтгүй тусламжийн 80.3 хувь буюу 1,204,747.9 ам.долларыг тус тус зарцуулсан байна.

2.Төслийн нийт хөрөнгө оруулалтын 70 гаруй хувийг бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, хадлан бэлтгэлийг сайжруулах ажилд зарцуулсан байна. Төслийн хүрээнд 2013-2016 оны хооронд нийт 4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг сумдад зарцуулсан байна. Тухайлбал худаг шинээр гаргах, хөв цөөрөм байгуулах, өвс тэжээлийн агуулах саравч барих ажлууд багтаж байна.

3.Тус төслийн жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 93.6 хувьтай, төсөл хэрэгжсэнээс хойших хэрэгжилт 89.1 хувь буюу “Хангалттай сайн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв.

4.Төслийн жилийн эцсийн тайлангийн тайлагналт нь үр дүнд суурилсан, хэрэгжилтийн биелэлтийг төсөл хэрэгжиж буй сум, малчдын бүлгийн үзүүлэлтээр гарган, үр нөлөөллийг тодорхой тусгасан байна. Төслийг хэрэгжүүлэгч нэгж нь Төрийн болон төрийн бус байгууллагууд, төсөлд хамрагдсан сумдын малчдын ажлын уялдаа холбоо хангалттай сайн байна.

5. Төслийн менежмент ба бодлогын дэмжлэгийн хүрээний 2016 оны батлагдсан төсөв бүрэн зарцуулагдаагүй, тухайлбал батлагдсан хөрөнгө оруулалтын 46.8 хувь буюу 3.093.0 сая төгрөгийг төлөвлөсөн арга хэмжээнд зарцуулсан дүнтэй байна.Шалтгаан нь “Нэмүү өртөгийн сүлжээ” дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд аж ахуйн нэгжүүдэд олгогдох зээлийн эх үүсвэр болох 800 мян ам долларыг (2 тэрбум орчим төгрөг) санхүүжүүлэгч байгууллагаас төслийн дансанд орж ирээгүй байна.

#### **Зөвлөмж**

1.Тайлангийн эх хувьд дээр дурдсан нэмэлтүүдийг оруулж дахин бэлтгэн Сангийн болон ХХААХҮ-ийн яам, 5-н аймаг, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад 2017 оны 04 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг зөвлөж байна.

#### **“Хөдөө аж ахуйн маркетинг” төсөл**

**Төслийн зорилго.** Мал аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтолцооны ашиг шимийг сайжруулах, зах зээлтэй холбох, нэр төрлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангахад оршино.

### **ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Хүснэгт 20

Зардлын ангилал	Нийт төсөв, ам.доллар	2014-2016 онд зарцуулсан төсөв, ам.доллар	2016 онд зарцуулсан төсөв, ам.доллар	Төсвийн үлдэгдэл	
				ам.доллар	Хувь
Малчдыг зах зээлтэй холбох	4,776,861.8	2,593,581.5	1,692,569.3	2,183,280.3	45.7
Малын ашиг шим, чанарыг сайжруулах	4,378,714.8	3,971,111.9	2,393,166.6	407,602.9	9.3
Төслийн удирдлага	1,844,423.4	1,325,479.8	517,022.7	518,943.6	28.1
<b>ДҮН</b>	<b>11,000,000</b>	<b>7,890,173.2</b>	<b>4,602,758.6</b>	<b>3,109,826.8</b>	<b>28.3</b>

**Төслийн зорилтын хэрэгжилт, үр дүн.** Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор, Хөвсгөл аймгийн аймгийн 15 суманд хэрэгжиж байгаа энэхүү төслийн хэрэгжилтийг Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний 5 баг, төслийн техник туслалцааны баг болох НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Мал аж ахуйд суурилсан амьжиргааг цогц байдлаар дээшлүүлэх” төсөл, оролцогч сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг хамтран зохион байгуулдаг.

Нийт 11 сая ам. долларын санхүүжилттэй тус төслийн хүрээнд нэмүү өртгийн сүлжээний 12, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн 67, малын эрүүл мэндийн 67, малын үржлийн 41, малын тэжээл, тэжээллэгийн 18, нийт 205 дэд төслийг санхүүжүүлж, хөрөнгө оруулалт хийсэн. Байршлаар авч үзвэл Архангай аймагт 42, Баянхонгор аймагт 34, Говь-Алтай аймагт 49, Завхан аймагт 38, Хөвсгөл аймагт 39, Мал эмнэлэг хорио цээр, хяналтын цэгүүд бүхий Өвөрхангай, Булган, Төв аймагт тус тус 1 дэд төсөл хэрэгжиж байгаа ба төслийн нийт ашиг хүртэгчийн тоо 13334 байна.

#### **Дүгнэлт**

1.Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2016 оны эцэс хүртэлх хугацаанд нийт төсвийн 71.7 хувийг зарцуулсан бөгөөд төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 62.8 хувь, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл **75.0** хувь буюу “хангалттай” үнэлгээтэй байна.

2.Төсөл хэрэгжүүлэх нэгж 2016 онд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж оролцогч 5 аймгийн 15 суманд хэрэгжүүлж байгаа нэмүү өртгийн сүлжээний 12, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн 67, малын эрүүл мэндийн 67, малын үржлийн 41, малын тэжээл, тэжээллэгийн 18, нийт 205 дэд төслийг санхүүжүүлж, нийтдээ 4.6 сая ам.доллар буюу төслийн нийт зардлын 41.8 хувьтай тэнцэж хэмжээний төсөв зарцуулан ажилласан байна.

3.Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнахдаа Даян дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийн буцалтгүй тусламжийн TF014820 дугаартай гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн хамруулах, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангах, өмнөх жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

#### **Зөвлөмж**

1.Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр удаашралтай, хангалтгүй биелэлттэй гарсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангахад анхаарч ажиллах.

2.Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, санхүүжүүлсэн төслийн үр дүн, үр нөлөөг илэрхийлэх баримт, тоон мэдээлэл, судалгааны үр дүнг тайланд тодорхой тусгаж ирүүлэх.

#### **“Өмнөд өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийг дэмжих техник туслалцааны төслийн II үе шат” төсөл**

**Төслийн танилцуулга.** Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ хооронд 2009 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан ӨӨХА хэрэгжүүлэх тухай Гурван талт хэлэлцээр. ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ хооронд 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан GCP/MON/010/CPR төсөл хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн дагуу төсөл хэрэгжиж дууссан байна.

**Төслийн зорилго.**Монгол улсын “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

#### **Төслийн зорилтууд**

*Бүрэлдэхүүн хэсэг 1.* Мал аж ахуй. Мал аж ахуйн фермд мал үржлийн биотехнологи нэвтрүүлж УСҮТ-ийн генийн санг баяжуулах,

*Бүрэлдэхүүн хэсэг 2.* Тэжээл үйлдвэрлэл. Малын тэжээлийн ургамлын үр үржүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих, Баруун болон зүүн бүс /300 га туршилтын талбай/-д Хятадын тэжээл тариалах технологийг нэвтрүүлэх,

*Бүрэлдэхүүн хэсэг 3.* Зөгийн аж ахуй. Зүүн бүсийн зөгийн аж ахуй эрхлэгчдэд зөгий үржлийн үйлчилгээг нэвтрүүлэх, зөгийн балны чанарыг шалгах, зөгийн орчны ажиглалтын ур чадвар дээшлүүлэх,

*Бүрэлдэхүүн хэсэг 4.* Хүнсний ногооны үйлдвэрлэл болон цэцэрлэгжүүлэлт. Хүнсний ногооны үйлдвэрлэлд хүлэмжийн болон ил талбайн шинэ технологи нэвтрүүлэх /өвлийн нарлаг хүлэмж, өндөр чанарын үр, боловсруулах технологи гм/,

*Бүрэлдэхүүн хэсэг 5.* Цөөрмийн/Загасны аж ахуй. Загасны өндөг бойжуулагч байгуулах, өндөгний амьдрах хувийг нэмэгдүүлэх,

*Бүрэлдэхүүн хэсэг 6.* Тахианы аж ахуй. Төслийн эхний үе шатанд бий болсон лаборатори, тахианы эрүүл мэндийн үйлчилгээг үргэлжлүүлэх, Өндөглөгч тахианы аж ахуйн тэжээлийн шимт чанарыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тахиа өсгөх байр байгуулах,

*Бүрэлдэхүүн хэсэг 7.* Чадавх бүрдүүлэх. Сургагч сургах хөтөлбөр /6 аж ахуй/, Талбайн буюу үзүүлэх сургалтын хөтөлбөр, Лаборатори болон байгууламж байгуулах, Гарын авлага хэвлэх, Богино хэмжээний кино бэлтгэх, танилцах аялал,

**Төслийн нийт төсөв.** Үр, Тоног төхөөрөмж 145,573 ам.доллар буюу 306,133,890 сая төгрөг, Сургалт болон танилцах аялалд 90,614 ам доллар буюу 186,224,680 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Төслөөс зарцуулсан нийт хөрөнгө оруулалт 999,294 ам доллар болсон байна.

**Төсөл хэрэгжих хугацаа.** Төслийн ажил 2014 оны 11 дүгээр сараас 2016 оны 11 дүгээр сар хүртэл үргэлжилсэн байна.

**Төслийн санхүүжилт болон удирдлага.** Төслийн ажилд ХХААХҮ-ийн яамнаас 52,521 ам.доллар буюу 112,184,856 сая төгрөгийг зарцуулсан байна.Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнд дараах албаны хүмүүс орж ажилласан байна. Үүнд: *Төслийн Удирдах хорооны дарга:* (1). Л.Чой-ИшСБТГ-ын дарга (2014.10.31 -2015.02.04-ний өдөр хүртэл) (2). ГХХАХ-ийн дарга Т. Эрдэнэжаргал (2015.02.04-2015.08.27-ны өдөр хүртэл); (3) ХХААЯ-ны ТНБДарга Н.Ариунболд (2015.08.27- );*Үндэсний зохицуулагч:* (1) О.Баярсайхан, ҮХААЯ-ны Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны захирал (2014.10.31 -2015.08.27-ны өдөр хүртэл); (2) ГХХАХ-ийн дарга Б. Биндэръяа (2015.08.27- ); *Хятадын багийн ахлагч, зохицуулагч:* Чанг Хайшан (2014.10.31- ); *НҮБ-ын ХХААБ-ын Төслийн үндэсний менежер:* Г. Гантулга (2014.10.07 – )

**Төслийн ажлын хэрэгжилт.** Төслийн ажлыг 7 үндсэн бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. Үүнд:



**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ**

Хүснэгт 21

д/д	Хөтөлбөрийн зорилт	Үнэлгээ
1	<u>Бүрэлдэхүүн хэсэг 1.</u> Мал аж ахуй. Мал аж ахуйн фермд мал үржлийн биотехнологи нэвтрүүлж УСҮТ-ийн генийн санг баяжуулах	100
2	<u>Бүрэлдэхүүн хэсэг 2.</u> Тэжээл үйлдвэрлэл. Малын тэжээлийн ургамлын үр үржүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих, Баруун болон зүүн бүс /300 га туршилтын талбай/-д Хятадын тэжээл тариалах технологийг нэвтрүүлэх	70
3	<u>Бүрэлдэхүүн хэсэг 3.</u> Зөгийн аж ахуй. Зүүн бүсийн зөгийн аж ахуй эрхлэгчдэд зөгий үржлийн үйлчилгээг нэвтрүүлэх, зөгийн балны чанарыг шалгах, зөгийн орчны ажиглалтын ур чадвар дээшлүүлэх	70
4	<u>Бүрэлдэхүүн хэсэг 4.</u> Хүнсний ногооны үйлдвэрлэл болон цэцэрлэгжүүлэлт. Хүнсний ногооны үйлдвэрлэлд хүлэмжийн болон ил талбайн шинэ технологи нэвтрүүлэх /өвлийн нарлаг хүлэмж, өндөр чанарын үр, боловсруулах технологи гм/,	70
5	<u>Бүрэлдэхүүн хэсэг 5.</u> Цөөрмийн/Загасны аж ахуй. Загасны өндөг бойжуулагч байгуулах, өндөгний амьдрах хувийг нэмэгдүүлэх,	90
6	<u>Бүрэлдэхүүн хэсэг 6.</u> Тахианы аж ахуй. Төслийн эхний үе шатанд бий болсон лаборатори, тахианы эрүүл мэндийн үйлчилгээг үргэлжлүүлэх, Өндөглөгч тахианы аж ахуйн тэжээлийн шимт чанарыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тахиа өсгөх байр байгуулах	90
7	<u>Бүрэлдэхүүн хэсэг 7.</u> Чадавх бүрдүүлэх. Сургагч сургах хөтөлбөр /6 аж ахуй/, Талбайн буюу үзүүлэх сургалтын хөтөлбөр, Лаборатори болон байгууламж байгуулах, Гарын авлага хэвлэх, Богино хэмжээний кино бэлтгэх, танилцах аялал,	90
<b>Дундаж</b>		<b>82.8</b>

**Дүгнэлт**

1.Төслийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 8 ажил тусгагдсанаас 2016 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 100.0 хувь, үр дүнгийн биелэлт 96.6 хувьтай дүгнэгдэж байна. 2016 онд үйл ажиллагааны, худалдан авах ажиллагааны болон сургалтын төлөвлөгөө тус тус гарган хэрэгжилтийг хангасан байна.

2.Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтээр тооцсон ба дунджаар 82.8 хувь, сургалтын төлөвлөгөөний биелэлт 100.0 хувь, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 90 хувьтай буюу 2016 оны ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ дунджаар 90.7 хувьтай байна.

3.Төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн “Хүнсний ногоог байгаль орчинд ээлтэй технологиор тарих ургуулах” ажлыг практикт нэвтрүүлэх ажлын хүрээнд 2 га газар төлөвлөсөн боловч, цахилгаан холбох зардал өндөр байсан тул энэ ажил хийгдэж чадаагүй байна.

4.Сургалтын төлөвлөгөөнд 6 сургалт, 2 семинар, 2 танилцах аялал, 1 зөвлөлдөх уулзалт, нийт 11 төрлийн үйл ажиллагаа тусгагдсанаас бүх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн буюу төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.

5.Төслийн ажлыг “Баруун болон зүүн бүсийн аймгийн 300 га талбайд тэжээл тариалах технологи нэвтрүүлэх” гэсэн заалтын хүрээнд зорилтот бүсийн аймгууд ороогүй, харин төвийн бүсийн Төв, Сэлэнгэ аймгууд сонгогдсон байна.

**Зөвлөмж**

1.Энэхүү төслөөс 2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн тайлан нь хэт товч, тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл ороогүй байгаа тул төслийн ажлын тайланг шинээр бүрдүүлэн авах шаардлагатай бөгөөд тайланг албан ёсоор хүлээн авч, хамтран ажилласан байгууллага, төсөл хэрэгжүүлсэн аймгуудад хүргүүлэх ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулах

**“НОГООН АЛТ” төсөл**

**Төслийн товч танилцуулга.** Төсөлд баруун бүсийн Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор зэрэг 7 аймаг хамрагдсан байна.

**Төслийн зорилго.** Бэлчээрийн нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих, малчдын зах зээл, эдийн засгийн харилцаанд идэвхтэй, үр өгөөжтэй оролцох, шинэ мэдлэг, мэдээллийг хурдацтай авах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

**Төслийн зорилтууд**

1. *Малчдын* байгууллагыг хөгжүүлэх. БАХ, Сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоодыг бэхжүүлэх замаар малчдыг бэлчээрийн тогтвортой менежмент, эдийн засгийн хөгжил, орон нутгийн засаглалд идэвхтэй, үр бүтээлтэй оролцох боломжуудыг нээх.

2. *Хэрэглээнд чиглэсэн судалгаа, туршилт.* Бэлчээрийн экологийн чадавхад суурилсан мал аж ахуйн менежментийг төлөвшүүлэх, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

3. *Эрэлтэд түшиглэсэн экстейншиний үйлчилгээг хөгжүүлэх.* Сумын төвшинд БАХ-д түшиглэсэн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэдээлэл дамжуулах сүлжээ, бүтэц зохион байгуулалтыг хөгжүүлэх.

4. *Маркетинг.* Сарлагийн хөөврийн түүхий эд бэлтгэл, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний чанар, технологийг сайжруулах замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх.

**Төслийн нийт төсөв.** Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилт 14.7 тэрбум төгрөг, түнш байгууллагуудын оруулах хувь 4.0 тэрбум төгрөг (түүнтэй тэнцэхүйц мөнгө, түүнийг орлох зүйлс), манай орны малчид, малчдын байгууллагуудын оруулах хувь 750.0 сая төгрөг (түүнтэй тэнцэхүйц мөнгө, түүнийг орлох зүйлс) гэж тооцсон байна.

**Төсөл хэрэгжих хугацаа.** Төсөл 2013 оны 1 дүгээр сараас 2016 оны 12 дугаар сарын 31 хүртэл үргэлжилж дууссан.

**Төслийн санхүүжилт болон зорилтын хэрэгжилт.** Төслийн 4 бүрэлдэхүүн хэсэг болон удирдлагын зардалд 2016 оны жилийн эцсийн байдлаар 2199.0 мянган швейцар франк төсөвлөж, 2528.2 мянган швейцар франк зарцуулж ба гүйцэтгэл 100-аас дээш хувийн биелэлттэй байна.

**ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХҮРСЭН ТҮВШИНГИЙН ҮНЭЛГЭЭ**

Хүснэгт 22

д/д	Зорилт	Үнэлгээ
1	Малчдын байгууллагыг хөгжүүлэх: БАХ, Сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоодыг бэхжүүлэх замаар малчдыг бэлчээрийн тогтвортой менежмент, эдийн засгийн хөгжил, орон нутгийн засаглалд идэвх, үр бүтээлтэй оролцох боломжуудыг нээх.	70.0
2	Хэрэглээнд чиглэсэн судалгаа, туршилт: Бэлчээрийн экологийн чадавхад суурилсан мал аж ахуйн менежментийг төлөвшүүлэх, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	100.0
3	Эрэлтэд түшиглэсэн экстейншиний үйлчилгээг хөгжүүлэх: Сумын төвшинд БАХ-д түшиглэсэн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэдээлэл дамжуулах сүлжээ, бүтэц зохион байгуулалтыг хөгжүүлэх.	100.0
4	Маркетинг: Сарлагийн хөөврийн түүхий эд бэлтгэл, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний чанар, технологийг сайжруулах замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх.	96.6
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>91.65</b>

**Дүгнэлт**

1.Төслийн ажилд 2013-2016 онд 10,580.0 мянган Швейцар франк батлагдсан, үүнээс 10,283.0 мянган Швейцар франк буюу батлагдсан төсвийн 97.1 хувийг төслийн ажилд зарцуулсан байна. Хэрэв нэг Швейцар франк 2400 төгрөг гэж үзвэл төслийн нийт батлагдсан төсөв 25,392,000,000 төгрөг, гүйцэтгэл нь 24,679,000,000 төгрөг буюу батлагдсан төсвөөс 712,320,000 төгрөгийг дутуу зарцуулсан дүнтэй байна.

2.“Ногоон Алт” төсөл хэрэгжсэнээс хойших буюу зорилтын биелэлт 91.65 хувь, 2016 оны төлөвлөгөөт ажлын биелэлт 100.0 хувиар тус тус үнэлэгдэв.

3.Төслийн зүгээс аймаг, сумдад байгуулсан Бэлчээр ашиглалтын хэсэг, Аймаг, сумдын болон Бэлчээр ашиглалтын үндэсний холбоо, хоршоод ба тэдгээрийн тогтвортой үйл ажиллагаа нь төслийн нэг гол үр дүн болсон байна. Тухайлбал Аймаг, сумд дахь малчдын байгууллагын үүсгэл санаачлагаар 2015 онд байгуулагдсан Бэлчээр ашиглагчдын үндэсний холбоонд төслийн

нэгжийн зарим үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэх арга хэмжээг 2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болжээ.

4.Энэхүү төсөл хэрэгжиж эхлэх үед аймаг, орон нутаг дахь анхан шатны хоршоод, үндэсний үйлдвэрлэгчидтэй гэрээ байгуулдаг байсан бол 2016 оноос эхлэн малчид “Дундын хоршоо”-гоор дамжуулан борлуулалтаа хийдэг болсноор бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн, зах зээлийн үнээр хоёр талын эрх ашигт нийцсэн гэрээ байгуулж эхэлсэн, ингэснээр төслийн эхэн үеэс 2016 онд хоршоодын байгуулсан гэрээний тоо 3.5, борлуулалт 4.7, шинээр бий болсон түр болон байнгын ажлын байрны тоо 2.4 дахин тус тус нэмэгдсэн үр дүн гарчээ. Гэрээ нь үндэсний үйлдвэрүүд бизнесийн үйл ажиллагаагаа тогтворжуулах, малчдаас худалдан авах бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарт хяналт тавьсан, хоршоод, үйлдвэрлэгчдийн урт хугацааны найдвартай түншлэлийг бий болгосон, түүхий эд нийлүүлэх ажлыг тогтмолжуулсан байна.

5.Төслийн хүрээнд 2006 оноос 10 жилийн хугацаанд аймаг, орон нутагт хийсэн судалгааны үр дүн, мэдээлэлд тулгуурлан боловсруулсан бэлчээрийн сэргэх чадавхын ангилал, төлөв байдлын өөрчлөлтийн загварууд дээр үндэслэн бэлчээр ашиглалт, МАА-н үйлдвэрлэлийг бэлчээрийн экологийн сэргэх чадавхад суурилан зохион байгуулах, чадавхыг үндэсний болон аймаг, сумын түвшинд бэхжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр үр дүнтэй ажилласан, аймгуудын бэлчээрийн экологийн зураглал бэлтгэсэн, энэ талаар олон тооны мэргэжилтэн бэлтгэсэн үр дүнтэй байна.

6.Төслийн эцсийн тайланг албан ёсоор хүлээн авах ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

### **Зөвлөмж**

1.Төслийн эцсийн тайланг нэгтгэн ирүүлээгүй, харин 2016 оны үйл ажиллагааны тайланг ирүүлсэн байх тул 2017 оны 04 дүгээр сард багтаан төслийн нэгдсэн тайланг яаманд ирүүлэхийг, төсөл болон яамны зүгээс энэхүү тайланг хэзээ хүлээн авах, 2 талаас хэн хэн гарын үсэг зурж, баталгаажуулах ажлыг хамтран зохион байгуулахыг,

2.Төслийн эцсийн тайланд аймаг, орон нутагт хийсэн бэлчээрийн зураглал, зураглал хийхэд ашигласан орчин үеийн программ хангамж, бусад тоон мэдээллийн талаар тодорхой мэдээлэл, тайлбар бэлтгэн оруулах, мөн түүнчлэн төслийн зүгээс худалдан авсан тоног төхөөрөмж, бараа материалын үнийн дүнгийн жагсаалтыг гаргаж тайланд хавсаргахыг,

3.Төслөөс гарах үр дүнгийн үр нөлөөллийг аймаг бүрээр гарган тооцон, үнэлж, тайланд (Тухайлбал: хичнээн сум бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн эсэх, төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан үр дүн, тэжээл тариалах, хадлан авах, дэмжлэгийг хичнээн малчин өрх, бүлэг ашиг шимийг хүртэж байгаа зэргийг тооцох гэх мэт) тусгахыг ,

4.Эцсийн тайланд сум бүрт хэрэгжүүлсэн арга хэмжээний санхүүгийн зарцуулалт, тухайн оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зэргийг тодорхой тусгаж ирүүлэхийг тус тус зөвлөмж болгож

### **1.5.3 Газар тариалангийн салбар дахь төслүүд**

Газар тариалангийн салбарт 3 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа ба эдгээрийн 2016 оны үйл ажиллагааны хэрэгжилт дунджаар ... хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **“Монгол ногоо” төсөл**

“Монгол ногоо” төсөл нь Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжийн хүрээнд 8.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 сарын 31-ны өдрийн хооронд хэрэгжихээр төлвөлсөн байна.

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага.** Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо ТББ, Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ;

**Зорилго.** Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

#### **Үр нөлөө**

Үр нөлөө 1.Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнс ний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

Үр нөлөө 2. Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсоноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна.

Үр нөлөө 3. Хотын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдүүлсэн байна.

Үр нөлөө 4. Хүнсний ногооны салбарын бодлого/хууль эрх зүйн орчин сайжирсан байна.

**Газар зүйн хамрах хүрээ:** Төв аймаг: *Борнуур, Жаргалант, Батсүмбэр, Баянчандмань сум (4)*; Сэлэнгэ аймаг: *Мандал, Шаамар, Хушаат, Зүүнбүрэн, Сант, Баянгол сум (6)*; Увс аймаг: *Улаангом сум (1)*; Дархан-Уул аймаг: *Орхон сум (1)*; Орхон аймаг: *Жаргалант сум (1)*; Улаанбаатар: *Хан-Уул, Сонгино-Хайрхан, Налайх дүүргийн нийт 4 хороо*; Бусад аймгийн 12 сум;

“Монгол ногоо” төслийн 2016 оны жилийн төсөв 2.4 тэрбум төгрөг, үүнээс гүйцэтгэлээр 1.7 тэрбум төгрөг зарцуулсан буюу 71 хувийн биелэлттэй байна.

**Төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүн.** 2016 онд нийт 8,342 га талбайд хүнсний ногоо тариалсан нь 2015 (6,803га) оны тариалалтаас 18 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бол ургацын дундаж 10.7 тн-оос (2015 он) 11.2 тн (2016 он) болж нэмэгджээ. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ 72,741т-оос (2015 он) 93,529 тн (2016 он) болж өссөнөөр дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 52 хувь (жишсэн хүн амын тоог 2,418.5 саяаар тооцлоо) болж өсжээ. (2015 онд 35 хувь).

Засгийн газрын 185 дугаар тогтоолоор, дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор импортын хүнсний ногооны гаалийн татварыг 5-10 хувиар буюу хүнсний ногооны төрөл зүйлээс хамаарч 20 хувь хүртэл хувиар нэмэгдүүлсэн байна.

2016 оны эхний хагас жилд газар тариалангийн төвийн бүсийн цаг уурын байдал тааламжтай байсан боловч 6, 7 дугаар саруудад ган, хураалтын үед буюу 8, 9 дүгээр сард үргэлжилж орсон бороо зарим төвийн бүсүүдэд ургац алдахад хүргэсэн. Мөн Увс аймгийн Улаангомд 7дугаар сарын сүүлчээр хүчтэй мөндөр бууж, хүнсний ногооны үүнд шар манжингийн үрийн талбайн ургац 30 хувиар буурсан байна.

Хүнсний ногооны маркетингийн судалгаагаар, импортын хүнсний ногооны 56 гаруй хувийг байцаа, сонгино, лууван гэсэн таримлууд эзэлж байна. Мөн импортын төмс, хүнсний ногооны 85 гаруй хувийг БНХАУ-аас хангаж байна гэсэн тоо баримт байна. (Хүнсний ногооны маркетингийн судалгаа, 2016).

Төслөөс хийсэн ядуурлын судалгааны дүнгээр, төслийн зорилтот дүүргийн нийт 14,198 өрхийн 3 хувь нь хашаандаа төмс, хүнсний ногоо тариалдаг. Өрхийн дундаж орлого 750,000 төгрөг байна. (Ядуурлын судалгаа, 2016)

“Монгол ногоо” төсөл 2016 оны 4 дүгээр сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Төсөл хэрэгжих хугацаа 4 жил, нийт төсөв 5 сая швейцар франк. Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. 2016 оны нийт төсөв 2.4 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Улсын Их Хурлын сонгууль 2016 онд болж өнгөрсөн. Сонгуулийн дараа яам, хэрэгжүүлэгч агентлагуудын удирдлага, мэргэжилтнүүд солигдсон, төсөл тариалалтын хугацаатай зэрэг буюу 4 дүгээр сард эхэлсэн зэрэг нь төслийн зарим үйл ажиллагаа хойшлогдоход нөлөөлсөн, мөн төслийн удирдах зөвлөл 2016 онд хуралдах тов тодорхойгүй хугацаагаар хойшилсон хэдий ч аливаа хүндрэл бэрхшээл тулгараагүй төсөл хэвийн үргэлжилсэн байна.

#### **Цаашид анхаарах асуудал**

1. Ногоочдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлын хүрээнд хэд хэдэн ажлууд хангалтгүй гүйцэтгэлтэй байна (5 га газар эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн үзүүлэн барих, Хүнсний ногооны үйлдвэрлэлийн мэдээллийн бааз санг үүсгэн баяжуулах гэх мэт).

2. Хүнсний ногооны маркетингийн сувгуудыг боловсронгуй болгох, борлуулалтын хоршоо байгуулах, хоршооллоор дамжуулсан хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах,

3. Монгол ногоо төслийн [www.mfard.mn](http://www.mfard.mn) цахим хуудас дээрх хүнсний ногооны зах зээл, үнэ ханшийн талаарх мэдээллийг бодит мэдээлэлд тулгуурлан тогтмол шинэчлэх, сайжруулах тал дээр анхаарч ажиллах,

4. Хүнсний ногоо боловсруулах төрөл бүрийн санаачлагыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга ажиллагааг төсөл хэрэгжиж буй аймаг сумдад зохион байгуулах ажлын үр дүнг сайжруулах,

5. Бүрэлдэхүүн хэсэг 4 болох Хүнсний ногооны салбарын бодлого хууль, эрх зүйн орчинг тогтвортой болгох зорилтыг эрчимжүүлэх, тухайн чиглэлээр ХХААХҮЯ-ны холбогдох газар хэлтсүүдтэй хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан ажиллахыг анхаарах шаардлагатай байна.

#### **“Буудайн элит үр гаргах, үржүүлэх” төсөл**

Энэхүү төсөл 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 14-ны өдөр хүртэл үргэлжлэхээр төлөвлөсөн байна.

**Төслийн нэр.** “Буудайн элит үр гаргах, үржүүлэх” төсөл

**Санхүүжүүлэгч.** БНСУ-ын КОПИА-Монгол төвийн 165.000 ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр төсөл хэрэгжиж байна.

**Хэрэгжүүлэгч.** Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэн

**Төслийн зорилтууд**

1. Монгол оронд нутагшсан буудайн сортуудын элит үр гаргах /эрт болцтой Дархан 131, дунд болцтой Дархан 34, Арвин /Дархан 166 /, дунд орой болцтой Дархан 144/ ба дараах сонголтуудыг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- ❖ Үрийн эх материал сонгох
- ❖ Анхдагч үрийн аж ахуй
- ❖ Элит үр үйлдвэрлэх

2. Буудайн арвин ургацтай, биохими технологийн чанар сайтай ган болон өвчинд тэсвэртэй селекцийн эх материал бий болгох. Үүнд:

- ❖ Солонгос болон Монгол орны буудайн сорт дээж солилцох, сорих, селекцид ашиглах
- ❖ Буудайн чанар, ган, халуун тэсвэрийг сайжруулах селекцийн ажил эхлүүлэх
- ❖ Буудайн селекцийн дугааруудад ургац, чанар, ган, халуун, өвчин тэсвэрийн үнэлгээ өгөх, шалгаруулах

**Төслийн үр дүн.** Селекцийн зориулалттай 40 удмыг 2015 онд сонгон шалгаруулж 2016 онд судалснаас дунд оройн болцтой Дархан-222 сорт нь хяналт Дархан-144 сортоос 3.5 ц/га-аар илүү ургац өгч уураг, цавуулгаар хяналт сортоос давж шалгарлаа. Төслийн дүнд Монгол оронд нутагшсан 4 сортын элит үр үйлдвэрлэх эх материал ганцаарчилсан ба бөөний сонголтын аргаар 15.3 тн бий болгон супер элит үр 47.3 тн, элит үр 22.5 тонныг тус тус үйлдвэрлэн шинэ сортуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эх үрийг бий болгосон.

Монгол орны цаг уурт дасан зохицсон сорт тариалах арга туршлагыг орон нутгийн хоршоод, фермүүдэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх хүрээнд 2016 оны 7дугаар сарын 28-ны өдөр 8 аймгийн 53 аж ахуй нэгж 90 гаруй тариаланчдад “Үр тариа болон буурцагт таримлын үр үржүүлэг” сэдэвт сургалт, талбайн өдөрлөг зохион байгуулснаар 3 аж ахуй нэгж, компанитай сорт солих, үр шинэчлэх гэрээ хийв.

Үр тарианы ургацыг тогтворжуулж, нэмэгдүүлэх чухал хүчин зүйлийн нэг нь орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон чанартай, арвин ургацтай сортын үрээр үйлдвэрлэлийг хангах явдал юм. Үрийн аж ахуй, үр судлалын шинжлэх ухааны судалгаагаар ургацын өсөлтийн 15-20% нь үрийн чанараас хамаардаг байна. Төслийн үр дүнгээс харахад Дархан-144, Дархан-131, Дархан-166, Дархан-34 сортууд нь хяналтаас 1.8-1.9 ц/га-аар нэмүү ургац өгч, 1 га-аас 1500,0 мян/төгрөгийн ашигтай байгааг харуулж байна. Төслийг хэрэгжүүлснээр элит үрийн тариалалтыг 10 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Улсын хэмжээнд импортоор оруулж байгаа үрийг 20 хувиар багасгаж байна.

**“Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл**

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл MNG16-01 2017 дугаартай төслийг 2016 оны 4 сараас 2018 оны 12 сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийн ажилтай холбоотой дараах хамтран ажиллах мэдэгдэл, хамтарсан мэдэгдэл гарсан байна. Үүнд:

1. ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яам болон МУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд 2007 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан хамтран ажиллах мэдэгдэл,

2. ХХХААЯ болон ХХААХҮЯ хооронд 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан “Герман-Монголын хамтын ажиллагааны-Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг хэрэгжүүлэх хамтарсан мэдэгдэл,

**Санхүүгийн эх үүсвэр.** ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яамны буцалтгүй тусламжаар хэрэгжинэ.

**Төслийн нийт төсөв.** 1,158,772 евро байх бөгөөд үүнээс 2016 оны гүйцэтгэл 303.600 евро байхаар төлөвлөсөн байна.

**Төслийг дэмжигч байгууллага.** Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ГФА Консалтинг групп яамыг төлөөлж төслийн ерөнхий захиалагчаар ажилладаг).

**Гол түншлэгч байгууллага.** Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,

**Хэрэгжүүлэгч байгууллага.** Консерциум: ИАК Аграр Консалтинг ХХК (гол хэрэгжүүлэгч), АФС Консултантс Интернэйшнл ХХК, ДОЙЛА Нийнбург ХХК, ДЛЖ Интернэйшнл ХХК зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна.

**Төслийн шалгуур үзүүлэлтүүд.** Хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомжууд нь олон улсад мөрдөгддөг дүрэм журам, стандартуудад тулгуурласан байна. Монгол Улс, ХБНГУ-ын хөдөө аж ахуйн салбар дахь мэргэжлийн солилцоо нь тогтмол үргэлжлэх юм байна.

**Төслийн 2016 оны үр дүн.** Төслийн нэгж ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Стратегийн бодлого, төлөвлөлтийн газартай маш ойр, нягт хамтран ажиллаж байгааг онцлох нь зүйтэй. Төслийн хоёрдугаар шатны анхны Удирдах хорооны хурлыг 2016 оны 11 сарын 15-нд ХБНГУ-ын Ханновер хотод зохион байгуулсан бөгөөд тус хуралд ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Саулегаар ахлуулсан төлөөлөгчид оролцсон. Энэхүү Удирдах хорооны хурлаар төслийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж баталж, яамны холбогдох газар, хэлтсүүдтэй хамтран хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Төслийн хүрээнд зохион байгуулж буй сургалт семинар, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлгүүд нь ХХААХҮЯ-ны хэрэгцээ шаардлагад тулгуурласан байдаг бөгөөд яамны холбогдох газар, хэлтэс хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, УИХ-аар хэлэлцүүлж, батлуулахаар боловсруулсан хууль, тогтоомжийн төслүүд, шинээр болон шинэчлэн батлагдсан хуулиуд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, оролцогчдын саналыг авч, ажилдаа тусган ажиллаж байна.

**Салбарын удирдах болон мэргэжлийн ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх, давтан сургалтууд.** 2016 оны 5 сарын 28-аас 6 сарын 4-ний хооронд ХБНГУ-д “Таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй”-н чиглэлээр танилцах аялал зохион байгуулсан. Тус аяллын бүрэлдэхүүнд ХХААХҮЯ, УГТХ-ийн холбогдох мэргэжилтнүүд хамрагдан Европын холбоо, ХБНГУ-д сортын сорилт, баталгаажуулалт, бүртгэл, зохиогчийн эрхийг хэрхэн хамгаалдаг талаар хууль эрхзүй, төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, салбарын тогтолцооны талаар танилцуулга сонсож, сорт сорилтын станцуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хамтын ажиллагааны эхлэлийг тавьжээ.

Төслөөс санаачлан ХХААХҮЯ, ХААИС болон Аймгийн ЗДТГ-тай хамтран “Тогтвортой хөдөө аж ахуй” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2016 оны 03дугаар сарын 09-10-ны хооронд Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулжээ. Тус сургалтад УИХ-аар шинэчлэн батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, эрх зүйн талаар танилцуулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, төрийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны төсөл, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авах, газар тариалангийн үйлдвэрлэл дэх хөрс хамгаалал, таримлын сэлгээнд тэжээлийн таримал тариалах технологи, махны үүлдрийн үхрийн аж ахуйн технологи сэдвүүд багтсан байна.

Төслөөс ХХААХҮЯ, ХААИС, УГТХ-тэй хамтран 2016 онд газар тариалангийн хөрс хамгаалал, хөрс бордох технологи, хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийн менежмент, даатгалын тогтолцоо, үр, сортын салбарын хүний нөөц, техник, тоног төхөөрөмж зэрэг сэдвүүдээр бодлогын зөвлөгөө өгөх, сургалт семинар, зөвлөгөөн, танилцах аяллыг амжилттай зохион байгуулсан. Эдгээрт давхардсан тоогоор 420 гаруй оролцогчид хамрагджээ.

**Төслийн туршилт, судалгааны ажлууд.** Төслийн нэгдүгээр үе шатанд эхлүүлсэн германы төмсний сортуудын судалгааны ажлыг хуучин загвар ААН болох “Элит-Үр” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Хушаат сумд байрлах талбайд туршиж, хэмжилт судалгаа хийх судлаачийг дэмжиж ажилласан. Тус судалгааны ажлын дүнд 2013 оноос нийт 34 сорт туршигдсанаас 4 сортыг шалгаруулан Улсын сорт сорилтод сорьж байна. Эндээс шалгарвал ирээдүйтэй сортоор батлагдах боломж бүрдэнэ.

**Төсөл, ХААИС-ийн хамтын ажиллагаа.** ХААИС болон түүний салбар дээд сургуулиудын эрдэмтэн багш, судлаачидтай хамтран мэргэжлийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Тухайлбал, “Монгол орны газар тариалангийн хөрсний элэгдэл, доройтол - шийдвэрлэх арга замууд” зөвлөгөөн, “Тариалангийн талбайн хөрсийг бордох арга технологи” сэдэвт сургалт, “Ургамал хамгааллын бодис, бордооны хэрэглээ, эрэлт, нийлүүлэлтийн талаарх зах зээлийн судалгаа” сэдэвт судалгааны ажил, “Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл” хэлэлцүүлэг хийгдсэн байна.

Түүнчлэн төслөөр дамжуулан ХААИС болон ХБНГУ-ын ДОЙЛА Нийнбург сургалтын төв хамтран ажиллах гэрээ байгуулан тус гэрээний дагуу мэргэжлийн ангийн 7 оюутан залуусыг орчин үеийн ХАА-н фермд 6 сарын үйлдвэрлэлийн дадлага хийлгэж, дэвшилтэт техник, технологитой газар дээр нь танилцуулсан нь төслийн нэг үр дүн билээ. Дараагийн ээлжийн оюутнууд хэлний бэлтгэлд хамрагдан бэлтгэлээ хангасан бөгөөд 2017 оны 4 сарын эхээр Герман руу явах бэлтгэлээ хангаж байгаа юм байна.

**Төсөл, УГТХ-ийн хамтын ажиллагаа.** Төслийн үндсэн чиглэлүүд болох таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй болон тогтвортой хөрс хамгаалал, ашиглалтын чиглэлүүдээр УГТХ-тэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, дээр дурдсан “Монгол орны газар тариалангийн хөрсний элэгдэл, доройтол - шийдвэрлэх арга замууд” зөвлөгөөн, “Тариалангийн талбайн хөрсийг бордох арга технологи” сэдэвт сургалтаас гадна “Сорт сорилтын салбарын удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг, хүний нөөц болон техникийн хангамж” сэдэвт семинар, “Хөрс боловсруулалт, бордооны зүй зохистой хэрэглээ” сэдэвт үйлдвэрлэгчдэд зориулсан гарын авлагыг зохиож байна.

## 2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт **92.2** хувьтай дүгнэгдэж, Төсвийн ерөнхийлөн захирагч нь Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг “А” буюу “хангалттай сайн” гэж үнэлжээ.

#### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 23

Гэрээний үзүүлэлт	Бүтээгдэхүүний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо
1. Нийт арга хэмжээ (тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих)-ний биелэлт	52	30.0	26.1
2. Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	65	40.0	36.1
3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт		30.0	30.0
Нийт оноо		100.0	92.2

### 2.2 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Тус яамнаас 2016 онд стратегийн 6 зорилтын хүрээнд 133 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн хүрсэн түвшинд үндэслэн хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл **89.3** хувьтай дүгнэгдэв. Тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаан нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдан байдал харьцангуй сайн байна.

#### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 24

Стратегийн зорилт, үйл ажиллагаа	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь
Стратегийн зорилт 1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр болон шийдвэрийн төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, эрх зүйн мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, цаг үеэ олсон бодлогын зөвлөгөө өгөх, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүг төлөвлөх, хэрэгжүүлэх;	35	84.65
Стратегийн зорилт 2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;	34	92.1
Стратегийн зорилт 3. Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	18	88.2
Стратегийн зорилт 4. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	17	92.3
Стратегийн зорилт 5. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	15	80.0
Стратегийн зорилт 6. Салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;	14	97.9
<b>ДҮН</b>	<b>133</b>	<b>89.3</b>

### 2.3 Салбарын 2016 оны үр дүн, гүйцэтгэлийг авч үзвэл

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-д хүнс, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 19.3 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 0.4 пунктээр өссөн байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН,  
(үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөг)

Хүснэгт 25

Салбар	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
ДНБ	16688419.55	19174242.59	22227054.3	23166779.1	-
Хөдөө аж ахуй /ХАА	1878786.37	2572044.89	2965360.5	3167566.3	-
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	601194.1	790171.2	919309.8	1002784.5	-
Нийтийн хоолны салбарын нийт үйлд.	332700	334100	316600	297400*	-
ХХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь	16.9	19.3	18.9	19.3	-

Эх үүсвэр: “Монгол улсын статистикийн эмхэтгэл” 2015, Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2016/12

\*БСЕГ-аас авсан урьдчилсан тооцоолол




График 1. Салбаруудын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь (үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр)

#### 2.3.1 Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг УИХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж 104 дүгээр тогтоолоор батлуулав.

“Малын генетик нөөцийн тухай”, “Органик хүнсний тухай”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай”, “Тариалангийн тухай” хуулиудын төслийг УИХ-д өргөн барьсан. Хуулиудын төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх дэд ажлын хэсгүүд БОХХАА-н Байнгын Хорооны тогтоолоор байгуулагдан ажиллаж байна.

Улирлаас хамаарсан махны үнийн хэлбэлзлийг тогтворжуулж махны нөөц бүрдүүлэх, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор “Мах” хөтөлбөрийг Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор батлуулав.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 332 дугаар тогтоолоор үхрийн шинэ эсхүл хөргөсөн мах; үхрийн хөлдүү мах; хонь, ямааны шинэ, хөргөсөн эсхүл хөлдүү мах; үхэр, гахай, хонь, ямаа, адуу, илжиг, луус эсхүл хөдий луусын шинэ, хөргөсөн эсхүл хөлдүү хүнсний дайвар мах; Мах, дайвар мах эсхүл цусаар хийсэн хиам болон түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл; Мах, дайвар мах эсхүл цусаар хийж бэлтгэсэн эсхүл нөөшилсөн бусад бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг 15 хувь, адууны мах, тэмээний болон бусад тэмээн төрөлтөн (Camelidia) амьтны мах, үхрийн махны импортын гаалийн албан татварыг 20 хувь болгон тус тус өөрчилсөн.

“Хүнсний аюулгүй сав” дэд хөтөлбөрийг ХХАА-н сайдын 2015 оны А/102 дугаар тушаалаар батлуулав.



“Мал аж ахуйн хөгжлийн тухай” болон “Үрийн тариалангийн даатгалын тухай”, “Тариалангийн даатгалын тухай” хуулийн үзэл баримтлалын болон хуулийн төслийг боловсруулж байна.

### 2.3.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Улсын хэмжээгээр 2016 оны эцэст 61549.2 мянган толгой мал, үүнээс 3635.5 мянган адуу, 4080.9 мянган үхэр, 401.3 мянган тэмээ, 27856.6 мянган хонь, 25574.9 мянган ямаа тоологдов. Малын тоо өмнөх оноос 5569.5 мянга /9.9 хувь/, адуу 340.2 /10.3 хувь/, үхэр 300.5 мянга /7.9 хувь/, тэмээ 33.4 /9.1 хувь/, хонь 2913.5 мянга /11.7 хувь/, ямаа 1981.9 мянга /8.4 хувь/-аар өссөн байна.

Өвөрхангай /5208.6 мянга/, Хөвсгөл /5089.4 мянга/, Архангай /5009.6 мянга/, Төв /4705.9/, Баянхонгор /4236.6/ аймаг 2016 онд хамгийн олон мал тоолуулж, малын тоогоор тэргүүлж байна.

### МАЛЫН ТОО, МЯНГАН ТОЛГОЙ

Хүснэгт 26

	2012 он	2013 он	2014 он	2015 УГ	2016 он
Адуу	2330.4	2619.4	2995.8	3294.6	3635,5
Үхэр	2584.6	2909.5	3413.9	3779.5	4080,9
Тэмээ	305.8	321.5	349.3	367.9	401,3
Хонь	18141.4	20066.4	23241.8	24933.4	27856,6
Ямаа	17558.7	19227.6	22008.9	23582.2	25574,9
Нийт дүн	40920.9	45144.3	51982.6	55957.6	<b>61549,2</b>

Эх сурвалж: Хөдөө аж ахуй 2016, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2016/12,

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2016 онд 92 толгой болж, өмнөх оноос 9 толгой /10.8/-гоор өслөө. Энэ үзүүлэлт Орхон аймагт 740, Улаанбаатар хтд 506, Дархан-Уул аймагт 353, Архангай аймагт 262, Булган аймагт 250 толгой болж, улсын дунджаас 158-648 толгойгоор их байна.

### ХАДЛАН, ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛ, МЯН.ТОННООР

Хүснэгт 27

Тэжээлийн төрөл	2011	2012	2013	2014	2015*	2016*
Байгалийн хадлан	1195.2	1175.1	1169.3	1178.7	1014.5	1100.0
Сүрэл	7.9	4.6	3.1	7.9	46.0	35.7
Гар тэжээл	46.7	39.1	36.6	40.3	42.5	38.1
Бэлтгэсэн дарш	8.5	2.1	3.9	4.0	3.2	7.9
Эрдэс тэжээл	40.4	36.6	31.8	38.1	124.1	105.6
Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд	663.2	624.6	609.8	614.0	1230.3	1287.3

\*-Урьдчилсан гүйцэтгэлээр

Эх сурвалж: Хөдөө аж ахуй 2016, Үндэсний статистикийн хороо

### ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР

Хүснэгт 28

Төрөл	2011	2012	2013	2014	2015*	2016*	2016/2015
Мах нядалгааны жингээр, мян.тн	208.2	220.1	249.7	245.8	373.1	<b>519,0</b>	<b>+145,9</b>
Тэмээний	6.2	5.3	6.7	6.3	8.2	10.3	+2.1
Адууны	23.7	31.2	29.8	31.1	50.8	72.0	+21.2
Үхрийн	53.6	59.7	57.7	54.7	93.2	135.6	+42.4
Хонины	79.1	67.2	91	92	134.6	186.3	+51.7
Ямааны	45.2	56.3	64	61.2	86.3	114.8	+28.5
Гахайны	0.4	0.4	0.5	0.5			-0.6
Сүү, мян.тн	458.6	588.0	666.9	765.4	874.3	<b>899,4</b>	<b>+25,1</b>
Ингэний	4.6	8.3	7.5	9.3	9.0	9.2	0.2
Гүүний	50.9	55.8	65.1	75	85.1	90.5	+5.4
Үнээний	298.8	337	380.6	440.4	512.4	520.5	+8.1
Хонины	33.4	64.5	74.2	84.7	95.2	99.2	+4
Ямааны	70.9	122.4	139.5	156	172.6	180.0	+7.4

Ноос, ноолуур, тн	23106	24890	28676.6	31602.4	36321.9	<b>44185.0</b>	+7863.1
Тэмээний ноос	1038.5	1079.3	1437.5	1516.6	1643.6	1805.8	+162.2
Хонины ноос	17646.6	17484.9	20229.2	22351.7	25820.8	33428.0	+7607.2
Ямааны ноолуур	4420.9	6325.8	7009.9	7734.1	8857.5	8951.2	+93.7
Арьс, мян.ш	8320.3	7511.5	9627.6	9160.3	13233.4		Тооцоологдоогүй
Тэмээ	23.1	29.4	27.4	93.2	36.0		Тооцоологдоогүй
Адуу	208	214.6	222.4	222.8	357.3		Тооцоологдоогүй
Үхэр	446.6	412.7	443.9	393.6	659.8		Тооцоологдоогүй
Хонь	4384.6	3293.5	4715.4	4517.2	6627.1		Тооцоологдоогүй
Ямаа	3258	3561.3	4218.5	3933.5	5553.2		Тооцоологдоогүй
Өндөг /сая.ш/	69.4	56.6	63.2	72.2	74.3	76.2	+1.9

Мал аж ахуйн бодлогын чиглэлээр дараах алжждыг гүйцэтгэсэн байна.

1."Малын генетик нөөцийн тухай" болон "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, хуулийн үзэл баримтлалын төслийг 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулав. "Малын генетик нөөцийн тухай" хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

2."Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

3. Малчдын бэлтгэж буй түүхий эд, бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор арьс, ширийг түүхийгээр нь 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл экспортлох боломжийг бүрдүүлэхээр Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 90 дүгээр тогтоолыг батлуулав.Энэ ажлын үр дүнд 500 төгрөгийн үнэтэй байсан хонины нэхийний үнэ 2500-3000 төгрөг болж өссөн байна.

4.Малын гоц халдварт шүлхий, малын мялзан өвчний голомтыг устгах, тархалтыг зогсоох, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах асуудлыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлуулав.

5. Улсын сайн малчин шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж хэлэлцүүлэн Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 202 дугаар тогтоолоор Улсын аварга малчин болгож өөрчлөн батлуулав. Журмыг шинэчлэн баталснаар малын тоог чухалчлах бус, малын чанар, ашиг шимийн үзүүлэлт, тэдний нийгэмд үзүүлж буй хувь нэмэр, бэлчээр ашиглалт зэрэг үзүүлэлтийг илүү харгалзан шалгаруулах болсон байна. 6.Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржлийн мал импортлох боомтуудын жагсаалтад нэмэлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

7.Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангах, олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт, халдварт, паразитгах өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг өндөржүүлж, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх зорилгоор "Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн төслийг боловсруулав.

8.Улсын хэмжээнд 2016 онд 19.1 сая төл хүлээн авч, оны эцсийн урьдчилсан дүнгээр 61.5 сая мал тоологдох төлөвтэй байгаа нь хамгийн олон төл авсан, малын тоо дээд хэмжээндээ хүрсэн он жил болохын зэрэгцээ Монгол Улсын эдийн засгийн суурь болох мал аж ахуйн салбар урьдчилсан байдлаар 10.0 гаруй хувиар өсөлттэй гарч байна.

9.Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний талаар гарсан Засгийн газрын 2016 оны 322 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан даалгаврыг орон нутагт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

10.Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр дүгнэхэд улсын хэмжээнд 82.8 хувьтай хангасан байна. Үүнд:

- ❖ Хадлан бэлтгэх ажилд 7101 дугуйт трактор, 5806 бага оврын тракторууд дагалдах хэрэгслийн хамт, 621 хаман боогч, 1000 морин хадуур, 5000 гар болон хөдөлгөөнт хадуур, тармуур ажиллаж малчдын түвшинд өвс 1.1 сая тн, сүрэл 35.8 мянган тн, ногоон тэжээл 22.3 мянган тн, үйлдвэрийн тэжээл 27.1 мянган тн, гар тэжээл 38.1 мянган тн, дарш 8.0 мянган тн, давс, хужир 105.6 мянган тн бэлтгэсэн байна.
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 32.0 мянган тн өвс, 13.1 мянган тн тэжээл бэлтгэх үүрэг даалгавар өгснөөс 20.4 мянган тн өвс, 4.5 мянган тн тэжээл бэлтгэсэн нь аймгийн түвшинд 75.9 хувь, сумдын түвшинд 50.7 хувиар биелүүлсэн хангалтгүй байсныг дахин бүрдүүлэлт хийх үүрэг өгснөөс Завхан, Сэлэнгэ, Өвөрхангай аймгууд аймгийн аюулгүйн нөөцөө 100 хувь бүрдүүлсэн.
- ❖ Улсын хэмжээнд 16460 өрхийн 6.9 сая мал отроор өвөлжиж, хаваржихаар зохион байгуулав. Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын отроор өвөлжиж буй өрхөд 2479 жирэмсэн эх, 0-5 насны 26,166 хүүхэд, 12,813 өндөр настан байгаа судалгаа байна.

11. 2016 онд улсын төсвийн 745.1 сая төгрөгөөр 42, гадаадын төсөл, хөтөлбөрийн 371.3 сая төгрөгөөр 27, орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгөөр 259 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачлагаар 354 гар худаг, нийт 682 худаг гаргасан нь 775.2 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрх, 1.9 сая малын усан хангамжийг нэмэгдүүллээ.

12. Бэлчээр хамгаалах чиглэлээр 2016 онд орон нутгийн малчдын оролцоотойгоор байгаль орчинд ээлтэй аргыг ашиглан бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 10 аймгийн 525.0 мянган га, царцаатай тэмцэх ажлыг 2 аймгийн 45.1 мянган га талбайд гүйцэтгэх ажлыг зохион байгуулав. Энэ ажлын үр дүнд бэлчээрийн даац багтаамжийг нийт 570.1 мянган га-аар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

13. Малын эмийн салбар зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулан бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг бүртгэх асуудлыг шийдвэрлэж хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллав.

14. Ховд аймгийн Булан автозамын боомтоор нэг удаагийн арга хэмжээ болгон БНХАУ-аас худалдан авах гоц халдварт мялзан өвчнөөс сэргийлэх 11.5 сая тун вакциныг нэвтрүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг батлуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

### 2.3.3 Газар тариалангийн салбар

Газар тариалангийн салбар дахь ургац хураалтын 2016 оны урьдчилсан дүнгээр нийтдээ 475.8 мянган тонн үр тариа, үүнээс 460.7 мянган тонн буудай, 153.7 мянган тонн төмс, 93.5 мянган тонн хүнсний ногоо, 19.6 мянган тонн тосны ургамал, 50.6 мянган тонн тэжээлийн ургамал буюу нэгжээс 14.0 цн улаанбуудай, 105.0 цн төмс, 112.1 цн хүнсний ногоо, 17.3 цн тэжээлийн ургамал, 3.1 цн тосны ургамал тус тус хураан аваад байна.

Аж ахуйн нэгж, иргэд 388.9 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 108.1 мянган га талбайг нь дэвшилтэд технологиор боловсруулсны зэрэгцээ дараа оны тариалалтад зориулан 45.5 мянган тонн үр нөөцөлсөн байна.

Энэ жилийн хувьд Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг бүхэлдээ Төв аймгийн зарим бүс нутгуудад хур тундас багатай гандуу байснаас ургац алдаж нэгжээс дунджаар 3.6-8.0 цн ургац хураан авсан байна.

Бусад бүс нутагт цаг агаар харьцангуй тааламжтай байж чамлахааргүй ургац бүрдсэн боловч 9, 10 дугаар саруудад нийт нутгаар хур тунадас ихтэй, талбайд техник ажиллах боломж хомс байсан нь хураалтын ажилд хүндрэл учруулан, ургацын хаягдлыг нэмэгдүүлснээр хураан авах боломжит ургацын хэмжээнд сөргөөр нөлөөллөө.



График 2. Үр тариа, хүнсний ногоо, төмсний үйлдвэрлэл

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар 197.5 мянган тонн багтаамжтай 3700 гаруй зоорь ашиглаж байна. 2016 онд төмс 153.5 мянган тонн, хүнсний ногоо 93,4 тус тус хураан авсан. Төмсөөр дотоодын хэрэгцээг бүрэн, хүнсний ногоогоор 52 хувь хангаж байна.

Төмс, хүнсний ногооны ургацыг зоорийн багтаамжтай харьцуулахад хадгалах хүчин чадлын хангамж 2016 оны байдлаар 80 хувьтай байна. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлээ дотоодын хэрэгцээгээ хангахад зоорийн багтаамжийг 100.0-110.0 мянган тонноор нэмэгдүүлэх шаардлагатай.

Монгол Улсын хэмжээнд хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилтэй 384 услалтын систем бүртгэгдсэн. 2016 онд усалгаатай тариалсан талбай 4.0 мянган га-аар нэмэгдэж 44.7 мянган га талбайд усалгаатай тариалсан байна. Нийт усалгаатай тариалах боломжтой талбайн хэмжээ 54.1 мянган га бөгөөд 2012 онд 50.1 мянган га талбайд тариалсан нь 2016 онтой харьцуулахад 8.9 хувиар буурсан дүнтэй байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд монгол орны хөрс, уур амьсгалын нөхцөлд тохирсон, тариалангийн үйлдвэрлэлийн технологийн болон бүтээгдэхүүний чанарын шаардлагад нийцсэн хийц, ажиллагаатай, ашиглалтын зардал бага гаргадаг, найдвартай ажиллагааны төвшин өндөртэй, байгаль орчинд сөрөг нөлөө бага үзүүлдэг трактор, комбайн, хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх чиглэл баримталж байна.

Үр тарианы техникийн шинэчлэл 65.0 хувьтай байна. Төмс, хүнсний ногооны механикжуулалтын төвшин хангалтгүй байгаагаас тарих, хураах, сортлох ажлын ихэнх хувийг гар аргаар гүйцэтгэж байгаа нь хөдөлмөр зарцуулалтыг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг бууруулж байна.

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого”, “Тариалангийн тухай хууль”, “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөр зэрэг эрх зүйн томоохон баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан тэдгээрийг тариаланчдад хүргэж сурталчлах, 2016 онд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээгээ танилцуулах, тариалангийн үйлдвэрлэлд нэвтэрч буй дэвшилтэт техник, технологийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Тариаланчдын Улсын зөвлөгөөн, “Хаврын тариалалт-техник, технологи” үзэсгэлэнг Дархан хотод зохион байгуулж 21 аймаг, нийслэлийн 700 гаруй тариаланчдыг хамруулав.

Тариалалтад дутагдах буудайн үрийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, тариалангийн зориулалттай шинэ техник тоног төхөөрөмж, бордоо ургамал хамгааллын бодис, усалгааны тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлүүлэх шийдвэрийг гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулав.

УИХ, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, 2016 оны тариалалтыг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2 жилийн хугацаатай, жилийн 12.5 хувийн хүүтэй 25.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банкаар шийдвэрлүүлж, улмаар ХААН, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж дамжуулан зээлдүүлэх ажлыг хэрэгжүүлснээр 92 гаруй аж ахуйн нэгжид 23.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.

Тариаланчдад учирч буй санхүүгийн дарамтыг багасгах, төлөвлөсөн хэмжээндээ тариалалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан нийтдээ 345 аж ахуйн нэгж, иргэнд 12.1 мянган тонн улаанбуудайн үр, 814 аж ахуйн нэгж, иргэнд онцгой албан татваргүй үнээр 4.1 мянган тонн шатахууныг 10-50 хувийн урьдчилгаатайгаар зээлээр олгож тариалалтын ажилд дэмжлэг үзүүлэв.

Буудайн үрийн чанар, хангамжийг сайжруулах зорилгоор 6.5 мянган тонн үрийн буудай импортоор авч 146 аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаатайгаар зээл олгосноор 40.6 мянган га-д чанар сайтай үрээр тариалах боломжийг бүрдүүлэв.

Дотооддоо нутагшсан таримлын элит үрийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй гэрээ байгуулж захиалгаар улаанбуудайн 4 сортын 344 тонн, бусад үр тарианы болон сэлгээний таримлын 180 тонн элит үрийг тус тус нийлүүлж нөөцийг бүрдүүлэв.

Япон улсын Засгийн газрын Засгийн газрын буцалтгүй тусламжийн КР-1 төслийн 8.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 7.9 мянган тонн нийлмэл бордоо нийлүүлж үнийг нь 60 хувиар хөнгөлөн 378 аж ахуйн нэгж иргэнд 75 хувийн урьдчилгаатайгаар олгов.

Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, уринш боловсруулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 288 аж ахуйн нэгж, иргэнд 233.3 тонн ургамал хамгааллын бодисыг 30 хувийн урьдчилгаа төлбөртэйгээр зээлээр олгов.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлэгдсэн 125-165 морины хүчтэй 15 ширхэг тракторыг 20 хувийн урьдчилгаа төлбөртэйгээр, 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 1035 ширхэг бага оврын тракторыг хөнгөлөлттэй нөхцлөөр тус тус борлуулав. Түүнчлэн БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн 24.5 сая ам.долларын хөрөнгөөр “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Швейцар Улсын техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжих “Монгол ногоо” төслийг эхлүүлж, эхний ээлжинд Дархан-Уул аймгийн Орхон суманд мэдээлэл технологийн төвийг нээж үйл ажиллагааг нь эхлүүлэв.

Хүнсний ногоо тариалагчдад зориулан аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан 50.0 сая төгрөгийн үнэ бүхий 5.3 тонн хүнсний ногооны үр олгов.

Намын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Алтан намар-2016” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 17 аймгийн 29 сум, нийслэлийн 5 дүүргийн нийт 300 ногоочин, 28 аж ахуйн нэгж, хоршоо оролцож нийслэлийн иргэдэд 420.0 тонн төмс, 24 нэр төрлийн 680 тонн хүнсний ногоог хямд үнээр борлуулах боломжийг бүрдүүлэв.

“Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд тус бүр нь 6 га талбайг услах 20 иж бүрдэл усанд хэмнэлттэй, дэвшилтэт дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлэв.

Тариаланчид, инженер техникийн ажилтнууд, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалагчдад зориулсан технологийн сургалтаар 15 удаагийн цуврал телевизийн нэвтрүүлэг бэлтгэж нийтийн хүртээл болгосны зэрэгцээ 4 төрлийн танхимын сургалтыг 6 аймаг, нийслэлийн дүүргүүдэд зохион байгуулж 1500 гаруй хүнийг хамруулав.

### 2.3.4 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, урьдчилсан гүйцэтгэлээр 2016 онд 1057967.8 сая төгрөгт хүрсэн нь 2015 оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувь, 2013 оныхтой харьцуулахад 33.9 хувиар тус тус нэмэгдэв. Хүнсний үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн салбарын 10 гаруй, ДНБ-ний 4 гаруй хувийг тус тус эзэлж энэ харьцаа тогтмол хадгалагдаж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний бусад бүтээгдэхүүн болон ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) 22.3, 3.2, 8.2 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төг

Хүснэгт 29

Бүтээгдэхүүний нэр төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он
<b>Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл</b>	<b>790171.2</b>	<b>919309.6</b>	<b>1002784.5</b>	<b>1057967.8</b>
Мах,загас, жимс ногоо, өөх тос боловсруулалт	130735.9	117891.6	90531.3	88893.9
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	44492.4	53567.3	52473.7	64185.1
Үр тариа, гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	141338.0	178213.4	189617.7	186194.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	100495.1	118844.5	131202.2	135411.5
Ундаа үйлдвэрлэл/согтууруулах ундаа ороод/	373109.8	450792.7	538959.7	583282.5

Эх үүсвэр: Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2016/12

Хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспорт 2016 онд 21.4 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.2 хувиар өсчээ. 2016 онд 8158.6 тонн адууны мах экспортолсон нь 2015 ба 2014 оны мөн үеийнхтэй харьцуулбал 2.1 ба 4.5 дахин их нэмэгдсэн байна.




График 3. Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импорт, мян ам доллар

Боломжит нөөцийг бүрэн ашиглах, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад худалдааны таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар тодорхой ажлууд хийгдэв. 2016-2018 онд БНХАУруу 6.0 тэрбум юанийн өртөг бүхий 150.0 мянган тонн үхэр, хонины мах нийлүүлэх санамж бичгийг үзэглэсэн. БНСВУ-ын ХААХХЯ-ны Мал эмнэлгийн газрын мэргэжилтнүүдийн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 2015 оны 5 сард, БНХАУ-ын ХААЯ, Чанарын хяналт, шалгалт хорио цээрийн газраас 8 хүний бүрэлдэхүүнтэй баг 2015 оны 9 сард Монгол Улсад тус тус ирж, мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд хянан магадлагаа хийсэн.

Үүний үр дүнд БНХАУ-д үхэр, хонины хөлдөөсөн мах, дулааны аргаар боловсруулсан мах, адууны мах экспортлох эрхийг давхардсан тоогоор 11 аж ахуйн нэгжид, БНСВУ-д дулааны аргаар боловсруулсан мах болон хонь, ямааны хөлдөөсөн мах экспортлох эрхийг 8 аж ахуйн нэгжид тус тус олгосон байна. БНХАУ-ын ХААЯ, ЧХШХЦЕГ-аас манай улсын баруун таван аймаг (Увс, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор)-ийн хувьд үхэр, хонины маханд тавьсан шүлхийн хоригийг цуцалсан тухай 2015 оны 140 дугаартай албан мэдэгдлийг БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт хорио цээрийн ерөнхий газрын (ЧХШХЦ) цахим хуудаст 12 дугаар сарын 07-ны өдөр албан ёсоор тавьжээ.

Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-ны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хүн амын /жишсэн хүн ам 2457,2 мян.хүн/ 2016 оны хүнсний хангамжийг тооцоход хүнсний гол 13 төрлийн бүтээгдэхүүнээс 5 төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангах нөөц байна.

**ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖ**  
/2016 оны эхний 12 сарын байдлаар /

Хүснэгт 30

д/д	Хүнсний төрөл	Жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн	Дотоодын үйлдвэрлэл, мян.тн	Импорт, мян.тн	Экспорт, мян.тн	Нийт хэрэглээ, мян.тн	Хангамж, хувь	Хангамж ид эзлэх дотоодын үйлдвэрлэлийн хувь, %	Хангамж ид эзлэх импорт ийн хувь, %
1	Мах, махан бүтээгдэхүүн	179.4	398.1	12.8	6.7	404.2	225.3	98.5	1.5
2	Сүү	54.8	134.7	23.1	8.9	488.4	362.6	97.1	2.9
3	Сүүн бүтээгдэхүүн	179.4	118.7	4.1	0.04	122.8	68.4	96.7	3.3
4	Гурил, тн*(Импортлоор оруулж ирсэн улаан буудайг гурилд шилжүүлэн тооцов)	235,8	219,4	145.7	2.2	367.3	155.8	59.7	40,3
5	Гурилан бүтээгдэхүүн	197.3	55.1	17.9	0.5	72.5	36.7	76.0	24.0
6	Төрөл бүрийн будаа	70	0	24.2	0.5	23.7	33.9	0	100.0
7	Саахар, чихрийн зүйл	20.6	0	89.1	0.3	88.9	431.6	0	100.0
8	Төмс	125.6	163.8	42.3	0	206.1	164.1	79.5	20.5
9	Хүнсний ногоо	179.4	72.3	80.0	0.8	151.5	84.4	47.7	52.3
10	Жимс, жимсгэнэ	161.4	2.1	37.4	1.2	38.3	23.6	5.5	94.5
11	Буурцагт ургамал	80.8	0	4.9	0	4.9	6.1	0	100.0
12	Өндөг, сая.ш	312.3	74.3	83,9	-	158.2	50,7	59.5	40.5
13	Хүнсний тос	22.4	1.6	19.7	0.4	20.9	93.3	7.7	92.3

*Эх үүсвэр: ХХААЯ, ХҮБХЗГ*

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжид дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд 2016 оны урьдчилсан дүнгээр хүнсний 10 гол нэрийн бүтээгдэхүүний 78,0 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа тооцооллыг яамны холбогдох газраас гаргасан нь “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хүнсний хангамж тогтвортой байгааг илтгэх үзүүлэлт болж байна.

**2016 онд хэрэгжүүлсэн дотоод аудит:** Тус яам нь ЗГ-ын бүтцийн өөрчлөлтөөр ХХААХҮЯам болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Дотоод аудитын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж бүрэн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мал хамгаалах сан, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн газар, “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-гийн

харьяа Дархан-Уул аймаг дахь “Үр тариа хадгалах 36.0 мянган тоннын багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор” худалдан авах үйл ажиллагаанд хийсэн шалгалт, Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон санхүүгийн аудит хийж, өмнөх онуудад гүйцэтгэсэн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж өгсөн. Мөн тус салбарт хэрэгжиж буй гадаадын “Ногоон алт” төслийн хэрэгжилтэд Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн, уг төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүдтэй хамтарч төсөл хэрэгжиж буй Архангай, Баянхонгор аймгуудын нийт 8 сумдад ажиллаж дотоод аудитыг гүйцэтгэв. Тайлант онд дээрх аудитад хамрагдсан байгууллагуудад хамаарах 7 газарт нийт 101 зөвлөмж гаргаж хүргүүлсэн болно. Дотоод аудит хийсэн тайланг яамны Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлж, яамны дотоод сүлжээний АСУ программын санд байршуулсан.

### 2.3 Хүнс, хөдөө аж ахуйн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас аймгуудын Засаг даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийг уг гэрээний дэлгэрэнгүй хувилбар болох аймгуудын ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн дүнгээр авав. Уг гэрээний холбогдох салбарт хамаарах бүтээгдэхүүний биелэлтийг яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд дүгнэж, Төрийн захиргааны удирдлагын газраас дүнг нэгтгэсэн байна. Үр дүнгийн гэрээнд аймгууд 40-59 бүтээгдэхүүн нийлүүлэхээр тусгасан ба дундаж үнэлгээ 84.5 хувьтай байна.

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2016 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН

Хүснэгт 31

№	Аймгууд	Нийт арга хэмжээ	Үр дүнгийн гэрээний биелэлт, салбараар			Гэрээний биелэлт ерөнхий дүн, хувь
			Хүнс	Мал аж ахуй	Газар тариалан	
1	Архангай	45	85	85.2	70	80.1
2	Баян-Өлгий	49	80	75.5	65	73.5
3	Баянхонгор	49	85	89.4	85	86.5
4	Булган	52	90	90.2	75	85.1
5	Говь-Алтай	46	85	90.0	75	83.3
6	Дорноговь	40	90	90.4	70	83.5
7	Дорнод	50	90	88.7	70	82.9
8	Дундговь	43	90	86.4	65	80.5
9	Завхан	49	90	81.6	75	82.2
10	Өвөрхангай	49	99	80.3	95	91.4
11	Өмнөговь	43	80	85.1	85	83.4
12	Сүхбаатар	43	90	85.9	70	82.0
13	Сэлэнгэ	59	95	81.6	100	92.2
14	Төв	55	90	76.0	90	85.3
15	Увс	52	85	78.0	90	84.3
16	Ховд	49	85	73.3	80	79.4
17	Хөвсгөл	51	95	80.3	90	88.4
18	Хэнтий	46	95	77.1	80	84.0
19	Дархан-Уул	56	98	91.9	80	90.0
20	Орхон	49	95	95.6	95	95.2
21	Говьсүмбэр	42	95	76.0	70	80.3
Дундаж үнэлгээ						<b>84.5</b>

### 2.4 Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон тайлан мэдээлэлтэй холбогдуулан тус яаманд албан тоотоор ирүүлсэн чиглэл, үүргийн биелэлт, яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас аймгуудын ХХААГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, Үндэсний аудитын газраас яамны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмж болон Монгол

Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар ҮАГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт гэсэн үзүүлэлтээр дүгнэв.

### ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 32

	Үзүүлэлт	Үнэлгээ, хувиар
1	ЗГХЭГ-аас ирүүлсэн ХШҮ-тэй холбоотой чиглэл, үүргийн хэрэгжилт	90.0
2	ХШҮ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /аймгуудын ХХААГ/	85.7
3	ҮАГ-аас яамны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлт	63.3
4	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар ҮАГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт	85.0
5	Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн талаар УИХ, Засгийн газраас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт	Зөвлөмж ирүүлээгүй
6	ЗГҮАХ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Засгийн газраас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт	
7	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Засгийн газраас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>81.0</b>

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон тайлан мэдээлэлтэй холбогдуулан тус яаманд албан тоотой ирүүлсэн чиглэл, үүргийн биелэлт, яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас аймагуудын ХХААГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, Үндэсний аудитын газраас яамны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмж болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар ҮАГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт гэсэн үзүүлэлтээр дүгнэв.

### 3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. Яамны 2016 оны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ **85.1** хувьтай дүгнэгдэв.

#### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 33

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	98.6
Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	70.0
Төсөв, санхүүгийн ил тод байдал	98.6
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	73.0
<b>Дундаж үнэлгээ</b>	<b>85.1</b>

а/ Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Яамны өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 371 шинэ мэдээ, Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 39 урилга, үр дүнгийн тайлан, хууль 3, УИХ-ын 3, Засгийн газрын 12 тогтоол, ХХААХҮ-н сайдын 7 тушаал, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 1 тушаал болон бусад холбогдох тайлан мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудаст шинээр байрлуулав. Мөн эдгээр мэдээлэл нь яамны дотоод мэдээллийн Е-оффис программд давхар орсон. Яамны вэбэд оруулсан дээрх мэдээллийг давхардсан тоогоор 7 хоногт 3500 гаруй хэрэглэгч үзэж танилцсан нь салбарын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хэрэглэгчдийг цаг үеийн шинэ мэдээллээр хангах ажилд ахиц, өөрчлөлт гарч байгааг харуулж байна. Мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үнэ төлбөргүй өгч байна. Тухайлбал, 2016 онд иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 281 хүнд 2212 хуудас баримтын хуулбар хувийг баталгаажуулан олгосон ба 166 хүнд 853 хадгаламжийн нэгж ашиглуулсан. УИХ-д өргөн барих хуулийн 4, ЗГ-ын тогтоолын 1, ХХААХҮ-н



сайдын тушаалаар батлагдах захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн 10 төслийг яамны цахим хуудсанд 30 хоног байршуулан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн төсөл боловсруулах журмын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэд, иргэдийн саналыг авч, тусган ажилласан.

### ***3.1.1 Хүний нөөцийн бодлогын ил тод байдал***

2016 онд хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх мэргэшсэн чадварлаг албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, төрийн албан хаагчийг давтан сургах, чадавхыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа. Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааг дүгнээд, гаргасан зөвлөмжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон, Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, яамнаас албан хаагчдад зориулан зохион байгуулах 2016 оны сургалтын төлөвлөгөө төсөв, “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгууллаа.

Төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг чиглэл, Салбар зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг үндэслэн Төрийн албаны Салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн үнэлсэн дүнгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагаа 12 яамнаас 2 дугаарт орсон байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, яамнаас албан хаагчдад зориулан зохион байгуулах 2016 оны сургалтын төлөвлөгөө төсөв, “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэхээр тусгасан. Төлөвлөсөн арга хэмжээний 49 арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Төлөвлөсөн арга хэмжээний 49 арга хэмжээ бүрэн биелсэн.

Яамны бүтэц, зохион байгуулалт 2016 оны 07 дугаар сарын 27-ний өдөр өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” ТНБД-ын 2016 оны 09 сарын 30-ний А-43 тоот тушаалаар яамны бүтцийн нэгжийн ажлын байр /албан тушаал/ -ны тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж ажиллаа. Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа албан хаагчдаас асуулга авч шинжилгээ хийж, ХХААХҮЯ-ны 98 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2016 оны байдлаар нийт Төрийн жинхэнэ албан тушаалын 11 сул орон тоо гарсан байна. Сул орон тооны судалгааг Салбар зөвлөлд тухай бүр танилцуулж ажиллаа. Төрийн жинхэнэ албанд орох иргэний нөөцөөс болон төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс 7 албан хаагчийг нэр дэвшүүлэн албан тушаалд томилсон.

Яамны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг хагас жилийн байдлаар Салбар зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар, бүтэн жилийн байдлаар Салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, үнэлгээг баталгаажуулав. Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн “А”, “В” үнэлгээ авсан 73 албан хаагчид мөнгөн урамшуулал олгож, зарим албан хаагчдыг Салбарын шагнал болон Сайдын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулав.

### ***3.1.2 Төсөв санхүүгийн ил тод байдал***

Салбарын төсвийн төсөөллийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон 2016 оны салбарын тэргүүлэх зорилтуудтай уялдуулан боловсруулсан. ХХААХҮйлдвэрийн салбарт улсын төсвөөс 201.9 тэрбум төгрөг батлуулан ажилласан. ХХААХҮйлдвэрийн салбарын 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) болон яамны цахим хуудасны төсөв, санхүү гэсэн буланд байрлуулсан.

ХХАА-н чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд 14 төрлийн тусгай зөвшөөрөл, үржлийн мал экспортод гаргах лиценз олгох, хугацаа сунгахад бүрдүүлэх бичиг баримт, тэмдэгтийн хураамжийн хэмжээг яамны цахим хуудсанд байрлуулсан.

### ***3.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал***

Сангийн яамнаас баталсан худалдан авах ажиллагаатай холбоотой журмыг байгууллагад мөрдөж ажилласан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн багцад батлагдсан төвлөрсөн арга хэмжээ, хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжүүлэх "Худалдан авах ажиллагааны

төлөвлөгөө батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-164 дүгээр тушаалаар урсгал зардлаар 23 тендер, мал хамгаалах сангийн хөрөнгөөр 4 тендер, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 9 тендер зарлагдсан.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-18 дугаар тушаалаар Тендерийн үнэлгээний хороодыг байгуулан ажилласан. Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар салбарын төсөв буурч батлагдсантай холбогдуулан 9 тендерийн худалдан авах ажиллагааг цуцалж, тендерийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-20 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

Үнэлгээний хороо тус бүрт тухайн салбарын 4 төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулж, тендерийн үнэлгээний хороонд ажилласан төрийн бус байгууллагын тэргүүн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй болох тухай мэдэгдлийг 3 удаа бичгээр авч авилгатай тэмцэх газрын цахим хуудсанд байршуулсан.

### **3.2. АТГ-аас байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ**

Тус яамны Авилгын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/1102 тоот албан бичгээр Авилгатай тэмцэх газарт хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд манай байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний талаар албан ёсны эдээ, мэдээлэл ирүүлээгүй тул яамны үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээнд оруулж тооцолгүй хассан болно.

## **4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

### **4.1. Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ**

Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Яамдын засаглалын үзүүлэлт”-ийг 2 дугаар хавсралтаар “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг тус тус баталсныг баримтлан 2016 оны байдлаар биелэлтийг гарган дүгнэв.

“Яамдын засаглалын үзүүлэлт”-ийн “Тухайн салбараас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлт” болон “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн урсгал өр, авлага” гэсэн үзүүлэлтүүд нь салбарын нэгтгэсэн тайлантай холбоотой бөгөөд “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь хэсэгт “... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, ...” гэж заасны дагуу уг тайлан эцэслэн гараагүй тул эдгээр үзүүлэлтийг дүгнэх боломжгүй байна. Иймд яамны засаглалын үзүүлэлтээс хасч, бусад 10 үзүүлэлт /14 дэд үзүүлэлт/-ээр үнэлэхэд яамны засаглалын үзүүлэлтийн гүйцэтгэл дунджаар **90.1** хувьтай дүгнэгдлээ.

“Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам гэсэн бүтцээр баталсан. Эдгээр үзүүлэлтээс хүнд болон төрийн өмчийн хороонд хамаарах үзүүлэлт ХХААХҮЯ-ны чиг үүрэгт хамааралгүй, мөн түүнчлэн ҮСХ-оос 2016 оны урьдчилсан гүйцэтгэл/мэдээлэл хараахан гараагүй тул “Нэг хүнд ногдож буй хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн” хэсэгт хамаарах үзүүлэлтүүдийг тус тус хасч биелэлтийг дүгнэлээ. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2016 оны биелэлт дунджаар **79.1** хувьтай дүгнэгдэв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг ҮСХ-оос гаргасан Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2015 он, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2016 оны 12 дугаар сар /урьдчилсан гүйцэтгэл/, яамны холбогдох газруудын тайлан, мэдээллийг үндэслэн тооцсон ба 2016 оны зорилтод түвшинтэй харьцуулан үнэлсэн болно.

### **4.2. Хэрэглэгчийн үнэлгээ**

“Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний тендерт гүйцэтгэгчээр “Улаанбаатар аудит корпораци” ХХК шалгарсан бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 20170214/09-022 тоот гэрээний дагуу гүйцэтгэлийг дүгнэн тайланг хүлээн авсан.

Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын хэрэгжилтийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Архангай, Сэлэнгэ, Орхон аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн насанд хүрсэн 2059 хэрэглэгчийг хамруулсан. Үүнээс МАА-н салбарын 480 (судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 23 хувь), газар тариалангийн салбарын 292 (14 хувь), хүнсний үйлдвэрийн салбарын 680 хэрэглэгч (33%), хөнгөн үйлдвэрийн салбарын 607 хэрэглэгчийг (30%) энэ удаагийн түүвэр судалгаанд хамруулан асуулгын аргачлалыг ашигласны зэрэгцээ асуулгын хариултыг 1-5 баллаар үнэлж, дүгнэлт гаргав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээний энэ удаагийн судалгаанд

хамрагдсан нийт хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэж салбарын ерөнхий үнэлгээ 85.0 хувьтай гарч байна.

## **5. ДҮГНЭЛТ**

5.1 Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн Бодлогын зорилтын хэрэгжилт, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал, Үйл ажиллагааны үр дүнг багцалсан үзүүлэлтээр **87.0** хувийн үнэлгээтэй буюу **4.35** гэсэн оноотой гарч байна. Тухайлбал Бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээний дундаж **86.3** хувь, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт үнэлгээний дундаж **87.5** хувь, Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж **87.7** хувь, Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээний дундаж **86.2** хувиар тус тус үнэлэгдэж байна.

5.2 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн байдлаар үнэлж үзэхэд хэрэгжилт дунджаар 18.0 хувь буюу хүрвэл зохих түвшингийн үнэлгээ 100 хувь биелэгдсэн байна. Тухайлбал төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 3 арга хэмжээ 50 хувь, 48 арга хэмжээ 30 хувь, 84 арга хэмжээ 10 хувийн биелэлттэй, харин 22 арга хэмжээг үнэлэх хугацаа болоогүй, 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

5.3 “Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээ гүйцэтгэсэн “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн судалгааны үр дүнгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ **85.6** хувьтай байгаа нь салбарын хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгааг илтгэж байна.

## **6. ЗӨВЛӨМЖ**

6.1 Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн Бодлогын зорилтын хэрэгжилт, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал, Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг гаргахад Бодлого, төлөвлөлтийн газар болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудын харилцан уялдаатай ажиллахыг,

6.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, УИХ-ын тогтоол, ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБ-ын зөвлөмж, Засгийн газрын шийдвэр, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүд, улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийн талаарх тайланг улирал тутам гаргаж, шаардлагатай тооцоо, мэдээллээр бусад газар хэлтэс болон ХШҮДАГ-ыг хангаж ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН  
(2016 оны үйл ажиллагааны үр дүн)**

д/д	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0	5.0
		2. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	80.3	4.0
		3. УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт	79.83	3.99
		4. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	-	-
		5. УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	84.6	4.23
		6. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт	84.9	4.12
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>86.3</b>	<b>4.27</b>	
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	92.2	4.6
		2. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	89.3	4.5
		3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	81.0	4.05
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>87.5</b>	<b>4.4</b>	
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	87.7	4.39
		2. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ-аас гаргасан үнэлгээ /	-	-
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>87.7</b>	<b>4.39</b>	
4	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Засаглалын үзүүлэлтийн үнэлгээ	90.1	4.5
		2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	83.0	4.15
		3. Хэрэглэгчийн үнэлгээ	85.6	4.25
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>86.2</b>	<b>4.30</b>	
<b>Ерөнхий үнэлгээ</b>		<b>87</b>	<b>4.35</b>	

**7. ХАВСРАЛТУУД**

1. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан,
2. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны ил тод байдлын үнэлгээний тайлан
3. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааг үнэлэх засаглалын үзүүлэлтийн биелэлт
4. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааг үнэлэх эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт
5. УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангууд
6. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийн тайлангууд
7. Хэрэглэгчийн үнэлгээний тайлан
8. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт